

**“БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ШИЛЖҮҮЛЭГ,
ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ**

БҮЛЭГ, ЗҮЙЛ	ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗААЛТ	ӨӨРЧЛӨЛТ	САНАЛ
ХУУЛИЙН НЭРШИЛ			
	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, <u>мөнгөн хөрөнгийн шилжүүлэг</u> , зээлийн үйл ажиллагааны тухай	Өөрчлөн найруулсан, “Төлбөр тооцоо” гэсэн томъёоллыг “мөнгөн хөрөнгийн шилжүүлэг” болгон өөрчилсөн.	1. Хуулийн төсөлд "мөнгөн хөрөнгийн шилжүүлэг" гэх нэр томъёог шинээр тусгаж, энэ ойлголтыг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.18-д зааснаар ойлгоно гэж, 2.3-т Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавихтай холбогдох харилцааг ҮТСтХуулиар зохицуулахаар заасан. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.18-д “шилжүүлэг” гэж аливаа этгээдээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг хэлнэ гээд, тус хуулиар тухайн шилжүүлэгтэй холбоотой харилцааг зохицуулжээ. Мөн хуулийн 5.1.1-т зааснаар “үндэсний төлбөрийн систем” гэж төгрөг, гадаад валютаар хийгдэх <i>шилжүүлэг болон төлбөрийн даалгаврын боловсруулалт хийх, илгээх, дамжуулах, хүлээн авахтай холбогдох үйлчилгээ</i>...тэдгээрийн цогц нэгдлийг хэлнэ гэсэн. 2. Харин хуулийн төслийн 3-р бүлэгт Шилжүүлгийн үйл ажиллагааг зохицуулсан бөгөөд тухайн бүлгээс үзэхэд мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, гүйлгээ, төлбөр гүйцэтгэх асуудлын тусгажээ. Гэтэл Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6.3.3-т үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг зохицуулах, шинээр төлбөрийн хэрэгсэл гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах бүрэн эрхийг Монголбанк хэрэгжүүлнэ гэжээ. <u>Эндээс үзэхэд Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд шилжүүлгийн асуудлыг нэгэн зэрэг зохицуулж буй шалтгаан, үндэслэл, үялдаа нь тодорхойгүй байна. Хэрэв Үндэсний төлбөрийн системд хамаарах "шилжүүлэг"-тэй холбоотой харилцааг</u>

			тухайн асуудлыг нарийвчлан, тусгайлан зохицуулсан Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар дагнан зохицуулна гэж үзвэл Хуулийн төслийн 3-р бүлэгт тусгагдсан харилцааг Монголбанкнаас баталсан дүрэм, журмаар зохицуулна гэж үзэхээр байна. Иймд Хуулийн төслийг Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай хэрхэн уялдуулах, системчлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
			2. Иргэний хуулийн "445.8. Банк, төлбөр тооцоо хийх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хийх төлбөр тооцооны харилцааг хуулиар зохицуулна." гэж заасан. Энэ хуулинд орж буй мөнгөн шилжүүлгийн үйл ажиллагаа нь төлбөр тооцооны үйл ажиллагааны нэг хэсэг гэж үзэх эсэх. ҮТСтХ-ийн 5.1.26-д "Төлбөр тооцоо гэж хоёр ба түүнээс дээш талын хооронд хийгдсэн мөнгөн хөрөнгө, үнэт цаасны төлбөрийг дансанд тусгах үйл ажиллагааг" ойлгохоор заасан. Энэ агуулгаар авч үзвэл аливаа мөнгөн шилжүүлэг, төлбөрийн гүйлгээний цаана зайлшгүй төлбөр тооцоо явагдаж байдаг, гэхдээ энэ хуулинд хамааралгүй гэж ойлгох эсэх.
нэгдүгээр бүлэг. нийтлэг үндэслэл			
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	1.1.Энэ хуулийн зорилт нь банк, эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээд, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Өөрчлөн найруулсан	Монгол Улсын аль ч хуулинд "эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд" гэж хэн болох тухай тодорхойлолт байхгүй байна. Зүй нь уг тодорхойлолтыг Иргэний хуульд, хэрэв Иргэний хуулиар дан ганц зохицуулагдахгүй, зөвхөн энэ хуульд хамааралтай бол энэ хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт тодорхой тусгах. "...үйл ажиллагаа үзүүлэх..." гэснийг "<u>...үйлчилгээ үзүүлэх...</u>" гэх? Хүснэгтийн 1 дэх хэсэгт дурдсан саналыг үзнэ үү.

2 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж	2.1.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Банкны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	Өөрчлөн найруулсан, 5 хууль нэмэгдсэн, Үндсэн хууль хасагдсан	...тухай гэсний дараах хууль гэснийг хасах.
	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.	Хэвээр	
	2.3.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавихтай холбогдох харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.	Өөрчлөн найруулсан	Хүснэгтийн 1 дэх хэсэгт дурдсан саналыг үзнэ үү.
3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ	3.1.Энэ хууль нь банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж (цаашид “хадгаламж” гэх), мөнгөн хөрөнгийн шилжүүлэг (цаашид “шилжүүлэг” гэх) болон зээлийн үйл ажиллагаанд үйлчилнэ.	Шинээр нэмэгдсэн	Мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн асуудлыг энэ хуулиар зохицуулах асуудлаар Хүснэгтийн 1 дэх хэсэгт дурдсан саналыг үзнэ үү.
	3.2.Энэ хуулиар иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх шилжүүлэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.	Шинээр нэмэгдсэн	Хуулийн төслийн 1.1-т өгсөн саналтай адил.
	3.3.Хуульд заасны дагуу хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн шилжүүлгийн үйл ажиллагаа энэ хуульд хамаарна.	Шинээр нэмэгдсэн	...хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээд гэж хэн болох талаар тодорхойлолт энэ хуулийн төсөл болон МУ-ын бусад хуульд байхгүй байх тул хуульд тодорхойлолтыг тодорхой тусгах.

4 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим	4.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээнд дараах зарчмыг баримтална: 4.1.1.нээлттэй, нийтэд ил тод байх;4.1.2.Нууцлал, аюулгүй байдлыг хангах;4.1.3.Тэгш оролцоог хангах.	Шинээр нэмэгдсэн	"нээлттэй,..." гэснийг "Нээлттэй,... " гэх
5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 5.1.1.“Зээл” гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр бусад этгээдэд аливаа хэлбэрээр олгосон мөнгөн хөрөнгийг;	Шинээр нэмэгдсэн	Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн "451.1. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ" гэж, 452 дугаар зүйлийн "452.1. Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно" гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн зохицуулалт хүүгүй байх боломжийг олгосон байхад хуулийн төсөл хүүтэй байхаар тусгасан нь энэ 2 хуулийн зохицуулалтыг зөрчилтэй болгож байна. Түүнээс гадна банк, санхүүгийн байгууллага зарим төрлийн зээл дээр зээлийн зориулалтыг тухайлан заадаггүй, мөн зориулалтыг тэр бүр хянах шаардлага гардаггүй, эсхүл хянах боломжгүй зээлүүд байдаг. Мөн практикт шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд хэдийнээ нэвтэрч байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд тусгасан энэхүү тодорхойлолт нь хэт хязгаарласан байх тул заалтыг <u>Иргэний хуулийн 451.1-д заасныг баримтлахаар өөрчлөх</u> . Мөн Иргэний хуулийн 189.1-т Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй. Өөрөөр хэлбэл, Иргэний эрх зүйн харилцаанд гэрээний эрх чөлөөт байдлын зарчим үйлчлэх тул зээл гэх ойлголтыг Иргэний хуульд зааснаас өөрөөр зохицуулах нь зөрчилтэй болохоор байна.
	5.1.2.“Ерөнхий нөхцөл” гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээд, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд үзүүлэх хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээнд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны нийтлэг зохицуулалтыг тусгасан баримт бичгийг;	Шинээр нэмэгдсэн	Ерөнхий нөхцөлд ихэвчлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг тусгаж, харин иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд холбогдох нөхцөл, талуудын хүлээн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тусгадаг. Ерөнхий нөхцөл гэдэг нь гэрээтэй нэг адил баримт бичиг болохоор байна. Ерөнхий нөхцөл, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний хоорондын ялгаа юу байх вэ? Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-т Ерөнхий нөхцөлийн агуулга, зарчим, тавих шаардлагыг Монголбанк, СЗХ батлахаар заасан тул 5.1.2-т заасан тодорхойлолт шаардлагатай эсэхийг эргэж хянах, эсхүл өөрчлөн найруулах

5.1.3. “Хадгаламж” гэж гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдээс банк, эрх бүхий хуулийн этгээдэд хадгалуулсан үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг болон гадаад улсын мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх мөнгөн хөрөнгийг;	Шинээр нэмэгдсэн	
5.1.4. “Төлбөрийн данс” гэж гэрээний үндсэн дээр банк, эрх бүхий хуулийн этгээдээс хэрэглэгчид төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр нээсэн дансыг;	Шинээр нэмэгдсэн	1. Одоо мөрдөж байгаа хуульд мөнгөн хөрөнгийн шилжүүлэг бус, төлбөр тооцоон ыүйл ажиллагааг Иргэний хуульд заасан илүү өргөн агуулгаар зохицуулж, түүнтэй уялдан төлбөр тооцоо гүйцэтгэх данс мөн тэр утгаар зохицуулагдаж байгаа. Гэтэл шинэчлэн батлах хуулийн төсөлд төлбөр тооцооны үйл ажиллагааг мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйл ажиллагаа болгон тодорхой хэмжээнд хязгаарласан. Энэ тохиолдолд Төлбөрийн данс нь хуулийн энэ зохицуулалттай уялдан, хязгаартай хүрээнд буюу зөвхөн мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх хүрээнд зохицуулагдах эсэх. 2. Дансны нэрийг Төлбөрийн данс гэж нэрлэх нь оновчтой эсэх. Бэлэн мөнгөний орлого, зарлага, төлбөрийн болон шилжүүлгийн гүйлгээ хийх, орлого хүлээн авах зэрэг олон төрлийн гүйлгээг хийх боломжтой, нэр томъёоны хувьд төөрөгдөл үүсгэхээргүй байх шаардлагатай. ҮТСтХ-д заасан төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгө, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэгт зориулан нээсэн данс энд хамаарах эсэх. Мөн Иргэний хууль, Банкны тухай хууль, ҮТСтХ, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль зэрэгтэй уялдаа, зааг, ялгааг тодорхой болгох. 3. Энэ заалтад төлбөрийн дансыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр нээсэн данс гэж тодорхойлжээ. ҮТСтХ-ийн 5.1.16. “төлбөрийн үйлчилгээ” гэж бэлэн мөнгөний орлого, зарлага, шилжүүлэг хийх, төлбөр шилжүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах, мөнгөн гуйвуулга хийх, цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх болон Монголбанкнаас тодорхойлсон мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон бусад үйлчилгээг; гэж тодорхойлсон бөгөөд энэ хуулиар зохицуулж буй мөнгөн хөрөнгийн шилжүүлэг нь төлбөрийн үйлчилгээний зөвхөн ганц үйлчилгээ юм. Монгол Улсын хуулиудад төлбөр гэж юу болох талаар тодорхойлолт байхгүй байна.

		4. Иргэний хуулийн 445 дугаар зүйлийн "445.1.Төлбөр тооцооны гэрээгээр банк, эрх бүхий бусад хуулийн этгээд /цаашид “төлбөр тооцоо гүйцэтгэгч” гэх/ нь иргэн болон хуулийн этгээд /цаашид “харилцагч” гэх/-ийн бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээнэ.", "445.2.Хуульд өөрөөр заагаагүй бол бэлнээр хийх төлбөр тооцоог банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэж болно.", "445.3.Бэлэн бусаар хийх төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр гүйцэтгэж болно." гэж заасан.
		5. Энэ заалтад тусгасан Хэрэглэгч гэж хэн болох тодорхойлолт энэ хуулинд байхгүй байна. ҮТСтХуулийн 5.1.10-т төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс үйлчилгээ авч байгаа аливаа этгээдийг гэж заасан. Хуулинд хэрэглэсэн нэр томъёог ашиглах эсэх, эсхүл "Хэрэглэгч" гэснийг нэр томъёоны тайлбарт нэмэх.
5.1.5.“Хүү” гэж гэрээний үндсэн дээр мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөр буюу үнийг; Тайлбар:зээл, хадгаламжийн үнэ бөгөөд хөрөнгө эзэмшигчийн хувьд орлого, ашиглагчийн хувьд зардлыг ойлгоно.	Шинээр нэмэгдсэн	Тайлбар хэсгийг хасах. Хуулийг хэрэглэх тайлбарыг Дээд шүүх гаргадаг. Хүү гэх ойлголт нь зөвхөн энэ хуулиар хязгаарлагдахгүй, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу өргөн хүрээнд ашиглагддаг тул хүүгийн талаар ерөнхий ойлголтыг зөвхөн энэ хуулиар зохицуулах нь оновчгүй байна.
5.1.6.“Шилжүүлэг” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.18-д заасныг;	Шинээр нэмэгдсэн	Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг ҮТСтХуулиар зохицуулахаар заасан. Энэ хуулиар зохицуулж буй мөнгөн шилжүүлэгийн үйл ажиллагаа нь ҮТСтХ-иар зохицуулсан үйл ажиллагаанаас юугаар, хэрхэн ялгарахыг тодорхой болгох. Мөнгөн шилжүүлгийн үйлчилгээнд аль хуулийн аль заалтыг баримтлах, хоорондоо зөрчилдсөн, эсхүл давхардсан утгатай зохицуулалтыг нэг мөр ойлгомжтой зохицуулах. Мөн Иргэний хуулийн 445 дугаар зүйлд заасан зохицуулалтыг харгалзан үзэх. Хүснэгтийн 1 дэх хэсэгт оруулсан саналыг үзнэ үү.

5.1.7. “Эрх бүхий хуулийн этгээд” гэж хуульд заасны дагуу Монголбанкнаас шилжүүлгийн үйл ажиллагаа, Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;	Шинээр нэмэгдсэн	1. ҮТСтХ-д шилжүүлгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэж байхгүй. Харин тус хуулийн 10.1.1-д Төлбөрийн үйлчилгээ эрхлэх, 10.1.9-д Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, 10.1.4. Төлбөрийн хэрэгсэл гаргах, 10.1.8. Мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ үзүүлэх, 10.1.10. Цахим мөнгө гаргах зөвшөөрлийг олгохоор, 10.2-т Төлбөрийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий этгээдэд 10.1.4-10.1.11-д заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг олгохоор заасан. Өөрөөр хэлбэл, эдгээр зөвшөөрөл нь бүгд мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйл ажиллагааг агүүлж байна. Энэ хуулийн төслийн 2.2-т Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавихтай холбогдох харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулахаар заасан. Иймд энэ хууль болон ҮТСтХ-ийн зохицуулалтын үялдаа болон ялгааг хангах зайлшгүй шаардлагатай байна. 2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.5. Төлбөрийн хэрэгсэл гаргах, 7.1.6. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хороо олгохоор заасан бөгөөд уг хуульд ҮТСтХууль батлагдсантай холбоотой уг зөвшөөрлийг Монголбанк олгох тухай өөрчлөлт ороогүй. Мөн Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуульд Монголбанк зөвшөөрөл өгөх зохицуулалт тусгагдаагүй. Өөрөөр хэлбэл, ББСБ-д Монголбанк зөвшөөрөл өгөх эрх нь эдгээр хууль тусгагдаагүй, ББСБ нь зөвхөн СЗХ-ны зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай байгаа бөгөөд ҮТСтХ-тай уялдуулан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хууль, Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байгаа. Хуулийн төслийн энэ тодорхойлолтоор ББСБ-ын уг үйл ажиллагаа энэ хуульд хамаарахгүй байхаар харагдаж байна. 3. Хуулийн төслийн 5.1.6-д "Шилжүүлэг" гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 5.1.18-д заасныг ойлгохоор заасан бөгөөд 5.1.18-д "Шилжүүлэг" гэж аливаа этгээдээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг ойлгох буюу Банкны хийж буй шилжүүлэг, төлбөр тооцооны үйл ажиллагаа энэ хуульд хамаарахгүй байна. Дэлгэрэнгүйг төслийн 17.1-д өгсөн комментоос харна уу.
---	-------------------------	---

			4. Иргэний хуулийн 445 дугаар зүйлд Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа гэж заасан тул "хадгаламж" гэснийг "мөнгөн хадгаламж" гэх? "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банкны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд заасан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй эрхлэх мөнгөн хадгаламж, зээл, төлбөрийн үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээд" гэх? Тэтгэврийн сан гэх мэт хэлбэрээр мөнгөн хадгаламж татаж байгаа үйл ажиллагааг тусад нь тусгай хуулиар зохицуулах эсэх. Мөн "зөвшөөрөл авсан этгээд" гэж томъёолохоор зөвшөөрөл авах шаардлагатай боловч зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй этгээдэд энэ хууль үйлчлэхгүй байх магадлалтай. Төрийн олон төрлийн сангаас зээл олгох үйл ажиллагаа энэ хуульд хамаарахгүй, холбогдох хууль, тогтоомж, ЗГ-аас баталсан журмуудаар зохицуулагдах эсэх. Мөн Хөгжлийн банкны тухай хуульд зарим үйл ажиллагааг энэхүү хуулиар зохицуулахаар заасан байна. Иймд Эрх бүхий этгээдийн хүрээг тодорхой болгох. Төрийн сангийн данс, шилжүүлгийн үйл ажиллагаа энэ хуулинд хамааралтай эсэх.
	5.1.8. "Эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг.	Шинээр нэмэгдсэн	4. Хуулийн төслийн 3.3-т заасан хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдийг энэ тодорхойлолтод нэмж тусгах эсэх.
6 дугаар зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдээс хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээ үзүүлэх журам	6.1. Банк, эрх бүхий хуулийн этгээд нь хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд баримтлах энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан ерөнхий нөхцөлийг нийтэд ил тод мэдээлнэ.	Шинээр нэмэгдсэн	
	6.2. Банк, эрх бүхий хуулийн этгээд нь иргэн, хуулийн этгээдэд хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлнэ.	Шинээр нэмэгдсэн	
	6.3. Энэ хуулийн 6.2-т заасны дагуу гэрээ байгуулахдаа иргэн, хуулийн этгээдийг тухайн үйлчилгээний болон гэрээний нөхцөлтэй танилцах боломж, нөхцөлөөр хангана.	Шинээр нэмэгдсэн	

	<u>6.4.Энэ хуулийн 2, 3, 4 дүгээр бүлэгт заасан үйл ажиллагааг зөвхөн хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан банк, эрх бүхий хуулийн этгээд эрхэлнэ.</u>	Шинээр нэмэгдсэн	Шилжүүлгийн зөвшөөрөл гэж тусгайлсан зохицуулалт ҮТСтХ-д байхгүй. Төлбөрийн үйлчилгээ эрхлэх (төлбөрийн хэрэгсэл гаргах, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ эрхлэх, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх, цахим мөнгө гаргах), Систем ажиллуулах зөвшөөрлүүд нь шилжүүлгийн үйлчилгээнд хамааралтай гэж ойлгож байна. Хуульд зөвшөөрөлтэй холбоотой зөрчилтэй болон ойлгомжгүй, орхигдсон зохицуулалтууд байгааг зайлшгүй өөрчлөх, сайжруулах шаардлага бий. Мөн зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэх тохиолдлууд гарч байгаа. Хуулийн төслийн 5.1.7-д хүргүүлсэн тусгасан саналыг харна уу.
7 дугаар зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх	<u>7.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан журмаар бичгээр гэрээ байгуулан данс нээсэн данс эзэмшигчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно.</u>	Шинээр нэмэгдсэн	
	<u>7.2.Энэ зүйлийн 7.1.-т заасны дагуу цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлгийн баримт, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ.</u>	Шинээр нэмэгдсэн	1. Иргэний хууль нь эдийн болон эдийн бус баялагтай холбоотой, хэлцэлтэй холбоотой харилцааг зохицуулсан суурь хууль бөгөөд тус хуульд хэлцлийг цахим хэлбэрээр байгуулах талаар зохицуулсан тул цахим хэлцэл байгуулах, цахим хэлцлийг нууц үг, нууц кодоор баталгаажуулах асуудлыг Иргэний хуулиар бататган зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна. Хуулийн төсөлтэй холбоотой дагалдах хуулийн төслөөс үзэхэд Иргэний хуульд цахим хэлцэлтэй холбоотой өөрчлөлт оруулах асуудлыг тусгаагүй байна. 2. Энэхүү хуулийн заалттай үялдуулан Иргэний хуулийн "42¹.2.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.", "43.2.4.цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан." гэсэн заалтад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах.

	<u>7.3.Банк, эрх бүхий хуулийн этгээд дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээдэд цахим хэлбэрээр аливаа данс нээхийг хориглоно.</u>	Шинээр нэмэгдсэн	1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд 5/ Банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлэхээр тусгасан бөгөөд энэ хүрээнд санхүүгийн харилцагчийг зайнаас таньж мэдэх, технологид суурилсан санхүүгийн цахим үйлчилгээг хэрэглэгчдэд хялбар хүргэх боломж ихээхэн хязгаарлагдмал, төрийн үйлчилгээний төлбөр, зээл болон хадгаламжийн үйлчилгээ зэргийг цахимаар хийхэд харилцагчийг зайнаас таних үйл ажиллагаа нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд хязгаарлагдаж байгаа, харилцагч санхүүгийн байгууллагад заавал биеэр очиж, бүртгүүлж, гэрээ байгуулахыг шаардаж буй одоогийн эрх зүйн орчныг өөрчлөх, тодорхой болгох шаардлага байгааг дурьдсан байна. МУ-ын Засгийн Газраас хэрэгжүүлж буй "Цахим засаг, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх" бодлогын хүрээнд энэ үйл ажиллагаа бүрэн цахимжих боломжтой болж байна. Иймд хуулийн энэ заалтыг цахим шилжилтийн цаашдын чиг хандлагад нийцүүлэн өөрчлөх. 2. Банк, эрх бүхий хуулийн этгээдэд санхүүгийн тогтвортой харилцаа үүсгэж байгаагүй этгээдэд ХУР, ДАН зэрэг Төрийн үйлчилгээний системд үндэслэн цахим хэлбэрээр танин мэдэх бүрэн боломжууд нээгдсэн тул цахим хэлбэрээр данс нээхийг зөвшөөрөх, шаардлагатай бол цахим хэлбэрээр данс нээсэн этгээдийн гүйлгээнд Монголбанкнаас тогтоосон хэмжээнд тодорхой хязгаарлалтыг баримтлахаар хуулийг зохицуулах нь оновчтой болов уу.
			3. Энэ хэсэгт дурдсан данс (дансгүй) гэж ямар төрлийн данс болох ойлгомжгүй байна. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Цахим мөнгөний журамд төлбөр тооцооны данс, цахим мөнгөний данс гэхчлэн байх боломжтой талаар зохицуулсан. Хуулийн төслийн энэ хэсэгт цахим, цахим бус болон бусад төрлийн хамааруулах бол эргэлзээ үүсгэхгүй байх үүднээс тодорхой дурдах нь зүйтэй гэж үзэж байна. Мөн “Санхүүгийн тогтвортой харилцаа үүссэн” гэж ямар нөхцөл байдлыг ойлгох талаар тодруулах шаардлагатай байна. Тодорхой бус нөхцөл нь маргаан, үл ойлголцолд хүргэж болзошгүй тул тодорхой, нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

8 дугаар зүйл. Ерөнхий нөхцөл	<u>8.1.Банкны хадгаламж, шилжүүлэг, зээл, эрх бүхий хуулийн этгээдийн шилжүүлгийн үйл ажиллагаанд баримтлах ерөнхий нөхцөлийн агуулга, зарчим, хяналтын тогтолцоо түүнд тавих шаардлагыг Монголбанк, хуульд заасны дагуу хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хадгаламж, зээлийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийн агуулга, зарчим, хяналтын тогтолцоо түүнд тавих шаардлагыг Санхүүгийн зохицуулах хороо тус тусын хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд батална.</u>	Шинээр нэмэгдсэн	Эрх бүхий хуулийн этгээдийн шилжүүлгийн үйл ажиллагаа гэдэгт ҮТСтХ-иас тусдаа үйл ажиллагаа гэж ойлгох эсэх. ҮТСтХ-иар тодорхойлсон шилжүүлгийн үйл ажиллагаанд энэ хууль хамааралтай эсэх. Хяналтын тогтолцоо гэдэгт юу багтах, хэрхэн ойлгох вэ? Хуулийн төслийн 3.3-т заасан хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд хэн хяналт тавих, алинд нь хамаарах вэ?
	<u>8.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн үзүүлэх хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд баримтлах ерөнхий нөхцөлийг энэ хуулийн 8.1-д заасан санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас баталсан агуулга, зарчим, хяналтын тогтолцоо, түүнд тавих шаардлагад нийцүүлэн баталж, санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагад тэдгээрийн хяналт шалгалтын чиг үүргийн дагуу тус тус хүргүүлнэ.</u>	Шинээр нэмэгдсэн	
	<u>8.3.Энэ зүйлд заасан ерөнхий нөхцөлийг шинэчилсэн тухай бүр энэ зүйлийн 8.2-т заасны дагуу санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.</u>	Шинээр нэмэгдсэн	"Санхүүгийн хянан зохицуулах байгууллага" гэдгийг Хуулийн нэр, томъёоны тодорхойлолт хэсэгт "Банкны тухай хуулийн 3.1.11-т заасныг" хэрэглэхээр тусгах. Аудит, Татвар зэрэг байгууллагыг хамруулж ойлгох эсэх талаар эргэлзээ төрөхөөр байна.
	<u>8.4.Энэ зүйлд заасан ерөнхий нөхцөлд эрх бүхий хуулийн этгээдээс иргэн хуулийн этгээдэд үзүүлэх хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээний нөхцөл, талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагааны журмыг тусгасан байна.</u>	Шинээр нэмэгдсэн	Энэ заалтыг хасах. Нэгэнт 8.1-т агуулга, тавигдах шаардлагыг Монголбанк, СЗХ батлахаар заасан. Ерөнхий нөхцөл нь тухайн үйлчилгээний болон үйл ажиллагааны журам, харилцагчтай байгуулдаг гэрээний хэмжээний баримт бичиг байхаар энд заасан байгаа ба эдгээр баримт бичгүүдийн хоорондын ялгаа юу байх нь ойлгомжгүй байна. Ерөнхий нөхцөл нь үйлчилгээний төрлөөс хамаарч ялгаатай байх боломжтой ба үүнийг хуулийн төслийн 8.1-т зааснаар Монголбанк, СЗХ-ны батлах баримт бичигт уян хатан тусгахаар зохицуулах нь оновчтой байна.
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хадгаламж, төлбөрийн данс		Өөрчлөн найруулсан	ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨРИЙН ДАНС (том үсгээр)

9 дүгээр зүйл. Хадгаламж, төлбөрийн данс нээх, хаах	9.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд хадгаламж, шилжүүлгийн үйл ажиллагаа эрхлэхдээ иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд (Цаашид “Харилцагч” гэх)-эд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан баримт бичиг, журмыг баримтлан хадгаламжийн, төлбөрийн данс нээж үйлчилгээ үзүүлнэ.	Өөрчлөн найруулсан	1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг уг хуулийн 4.1-т заасан этгээд зайлшгүй дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд уг хуулиар хадгаламжийн болон төлбөрийн данс нээхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулаагүй, гүйлгээ хийж буй этгээдийг таньж мэдэх, 20 сая төгрөгөөс дээш дүнтэй болон сэжигтэй гүйлгээнд хянал тавих, мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан. Иймд уг хуульд заасан журмыг баримтлан гэж томъёолох нь оновчгүй байх тул энэ заалтыг өөрчлөн найруулах.
			2. Төслийн 2.3-т зааснаар ҮТСтХ-д заасан үйл ажиллагаа, тухайлбал төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх үйл ажиллагаа, түүнтэй холбоотой данс нээх, хэрэглэгч бүртгэх үйл ажиллагаа тухайн хуулиар зохицуулагдана гэж ойлгох үү? Хэрэв үгүй бол энэ хуулинд, ҮТСтХ-нд нийцүүлэн гаргасан холбогдох зохицуулалтыг нэмэх. Тухайлбал, цахим мөнгө гаргагч цахим хэтэвч нээхэд харилцагчийг таньж мэдсэн эсэхээс хамаарч хэрэглэгчийн түвшинг ялгаатай тодорхойлж байгаа ба гүйлгээний хэмжээнд хязгаар тогтоож байгаа.
	9.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд иргэнд данс нээхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ. 9.2.1.хүсэлт; 9.2.2.мөнгөн хөрөнгө захиран зарцуулах этгээдийн төлбөрийн баримтад зурах гарын үсгийн маяг; <u>9.2.3.эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл.</u>	Өөрчлөн найруулсан	Цахим хэлбэрээр үзүүлж буй төлбөрийн болон шилжүүлгийн үйлчилгээнд данс нээх болон гүйлгээ хийхэд хүсэлтийг Харилцагч/Хэрэглэгчээс цахим хэлбэрээр авч, нууц үг, гүйлгээний нууц үг зэргээр баталгааждаг, уг баталгаажсан мэдээлэл нь цахим хэлбэрээр хадгалагддаг. Мөн цаашид харилцагчийг цахимаар таньж мэдэх боломжууд нээгдэх бүрэн боломжтой тул цахимаар данс нээхэд уян хатан байх нөхцөлийг хуулинд нэмж тусгах.
	<u>9.3.Банк, эрх бүхий хуулийн этгээд хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд данс нээхдээ дараах баримт бичгийг бүрдүүлнэ.</u> <u>9.3.1.хүсэлт;</u> <u>9.3.2.дүрэм, түүнтэй адилтгах бичиг баримт</u> <u>9.3.3.тамга, тэмдгийн дардас;</u> <u>9.3.5.мөнгөн хөрөнгө захиран зарцуулах албан тушаалтны овог нэр, төлбөрийн баримтад зурах гарын үсгийн маяг. Гарын үсгийн маяг нь нотариатаар гэрчлүүлсэн байна;</u> <u>9.3.6.эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл.</u>	Шинээр нэмсэн	1. 9.2 заалттай ижил, цахим хэлбэрээр данс нээх тохиолдолд зохицуулалтыг нэмж тусгах. 2. 9.3.4 дугаарлалт алгассан байгааг засах.

9.4.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд болон гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд тэдгээрийг хянан зохицуулж байгаа эрх бүхий этгээдээс тамга, тэмдэг хэрэглэх шаардлага тавьдаггүй тохиолдолд энэ хуулийн 9.3.3 дахь заалт хамаарахгүй.	Шинээр нэмсэн	Энэ зохицуулалтад дурьдсан эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд гэдэг тодорхойлолтыг хуулинд тусгах (өмнөх заалтуудын саналд дурьдсан)
9.5.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь өөрийн харилцагчид төлбөрийн болон хадгаламжийн данс дахин нээх тохиолдолд тухайн харилцагчийн баримт бичигт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг шинэчлэн авах үүрэгтэй.	Шинээр нэмсэн	Дан ганц баримт бичгээр бус Төрийн үйлчилгээний e-mongolia болон ХУР, ДАН зэрэг үйлчилгээний платформоор дамжуулан харилцагчийн мэдээллийг шинэчлэх боломжууд бий тул цахим хэлбэрээр мэдээллийг шинэчлэх зохицуулалыг хуулинд тусгах.
9.6.Харилцагч 9.5-д заасны дагуу банк, эрх бүхий хуулийн этгээдээс шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзсан бол Банк, эрх бүхий хуулийн этгээд нь үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, дансыг хаах хүртэл арга хэмжээ авна.	Шинээр нэмсэн	
9.7.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан баримт бичгийг хянан үзээд 10 хоногийн дотор данс нээх буюу эдгээр баримт бичгүүд хуульд заасан шаардлага хангаагүй бол данс нээхээс татгалзана.		2, 3 дахь хэсэгт гэснийг 9.2, 9.3-т заасан гэх.Баримт бичгээр хязгаарлагдахгүй, цахим хэлбэрээр гаргасан хүсэлт, баталгаажсан мэдээллийг үндэслэх боломжийг хуулинд тусгах. Хэрэв энэ хуулинд ҮТСтХ-иар зохицуулагдах үйлчилгээ, түүнтэй холбоотой цахим данс нээх үйл ажиллагаа хамааралтай гэж үзвэл
9.8.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд дансыг хааж болно. 9.8.1.харилцагч данс хаалгах хүсэлтээ бичгээр гаргасан; 9.8.2.харилцагчтай байгуулсан гэрээнд заасан нөхцөл биелэгдсэн;		1. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч гэдэгт хэнийг ойлгохыг энэ хуульд тодорхой тусгах. ҮТСтХ-ийн 5.1.14-т заасан "Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч" нь энэ зохицуулалтад хамааралтай юу? Хэрэв тийм бол хуулийн төслийн 2.3 заалттай зөрчилдөх эсэх. Мөн энэ хуулийн төсөлд зохицуулсан Шилжүүлгийн үйлчилгээ ҮТСтХ-ийн зохицуулалтаас хэрхэн ялгарах вэ? "Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч" гэснийг "Банк, эрх бүхий этгээд" гэх?

	9.8.3.энэ хуулийн 9.6 дахь хэсэгт заасан нөхцөл бүрдсэн; 9.8.4.хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.		2. "9.8.1."-д харилцагч данс хаалгах хүсэлтээ заавал бичгээр гаргахыг шаардах шаардлагатай эсэх. Идэвхгүй, тодорхой хугацаанд гүйлгээ хийгээгүй, 0 үлдэгдэлтэй дансыг Банк, эрх бүхий этгээд хаах бүрэн боломжийг хуулинд заах, хэдийгээр энэ зохицуулалт 9.8.2-т заасан нөхцөлөөр хэрэгжих боловч гэрээнд данс хаах нөхцөлийг тодорхой тусгаагүй тохиолдолд хэрэгжих боломжгүй байна. Мөн цахим хэлбэрээр данс хаах бүрэн боломжтой.
	<u>9.9.Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн харилцагчийн техникийн хэрэгсэл, програм хангамжийг ашиглан илэрхийлсэн хүсэлтийг үндэслэн цахим хэлбэрээр данс нээж, хааж болно.</u>	Шинээр нэмсэн	1. Энэхүү заалттай уялдуулан, 9.2, 9.3, 9.8 заалтуудад цахимаар хүсэлт илгээх буюу 9.9-т зааснаас бусад тохиолдолд гэсэн нөхцөлийг нэмж тусгах. Мөн цахимаар данс нээлгэх хүсэлтэд тавигдах шаардлагыг холбогдох хуулиудад нийцүүлэн Монголбанк батлахаар хуулинд зохицуулах. (цаашид цахим шилжилт, төрөөс цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний нөхцөлөөс хамаарч өөрчлөгдөх бүрэн боломжтой тул шаардлагыг Монголбанк зохицуулахаар тусгах). 2. Энэ заалтын найруулгыг засч сайжруулах (харилцагч өөрийн техник хэрэгсэл, програм хангамжийг ашиглан илэрхийлсэн хүсэлт мэтээр ойлгогдохоор байна.) Иргэний хууль болон бусад хуульд нийтлэх хэрэглэдэг цахим хэлбэрээр гэсэн нэр томъёог ашиглах. "Банк, эрх бүхий этгээд нь өөрийн харилцагчийн цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн данс нээж, хааж болно" гэх. Гэхдээ бусад хэсэгт дурьдсан цахим хэлбэрээр шинэ харилцагчийг бүртгэж, данс нээх, Монголбанкнаас тогтоосон хэмжээнд хязгаартай гүйлгээ хийх боломжтой байхаар зохицуулах.
	<u>9.10.Аливаа дансан дахь мөнгөн хөрөнгийн талаархи мэдээллийг бусдыг хуурч мэхлэх, хуурамч тодорхойлолт гаргах зорилгоор ашиглахыг хориглоно.</u>	Шинээр нэмсэн	Энэ заалт банк, эрх бүхий этгээд болон данс эзэмшигч иргэн, хуулийн этгээдэд аль алинд хамааралтай заалт уу? Аль нэг талд хамааралтай бол найруулгыг өөрчлөх, илүү тодорхой болгох.
	<u>9.11.Төрийн өөрийн өмчийн мөнгөн хөрөнгийг зөвхөн Монголбанкинд байршуулна.</u>	Шинээр нэмсэн	Төрийн сангийн данс, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг энэ хуулинд хамааралтай эсэх. Хэрэв хамааралгүй, холбогдох Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төрийн сангийн төлбөр тооцооны журам зэрэг хууль, эрх зүйн актаар зохицуулагдах бол уг хууль, эрх зүйн актуудад энэ зохицуулалтыг тусгах.
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА			ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭХ

10 дугаар зүйл. Хадгаламж	10.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд /цаашид “Хадгалагч” гэх/-ээс иргэн, хуулийн этгээд, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд /цаашид “Хадгалуулагч” гэх/-д Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан журмыг баримтлан гэрээ байгуулж хадгаламжийн үйлчилгээ үзүүлнэ.	Өөрчлөн найруулсан	Хуулийн нэрийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай гэж өөрчлөх. Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулах, түүнтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд Банк, эрх бүхий этгээд уг хуулийг энд заасан эсэхээс үл хамааран, дагаж мөрдөх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн гэрээ байгуулах, хадгаламжийн үйлчилгээ үзүүлэхэд баримтлах журмыг уг хуулиар зохицуулаагүй. Иймд энэ заалтын найруулгыг эргэн хянах.
	10.2.Хадгалагч нь хадгалуулагчтай хадгаламжийн гэрээ байгуулах үедээ өөрийн үйл ажиллагаатай холбоотой үнэн зөв мэдээллийг өгнө.	Хэвээр үлдээсэн	
	10.3.Хадгалагч нь өөрийн хадгаламжийн үйлчилгээний нөхцөл, эдгээр үйлчилгээг авч байгаа хадгалуулагчийн гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг тэдгээрт ойлгомжтой байдлаар танилцуулна.	Өөрчлөн найруулсан	
11 дүгээр зүйл. Хадгаламжийн гэрээ	11.1.Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хадгаламжийн гэрээгээр хадгалагч нь хадгалуулагчийн хадгаламжийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ.	Хэвээр үлдээсэн	
	11.2.Хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, хүү тооцох журам, гэрээ цуцлах, хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйгээс талуудын хүлээх хариуцлагыг заана.	Хэвээр үлдээсэн	
	11.3.Хадгалагч хадгалуулагчтай байгуулах хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн сертификат зэргээр бичгээр, <u>цахим хэлбэрээр эсхүл техникийн хэрэгсэл, програм хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлэн харилцан тохиролцсоны дагуу байгуулж болно.</u>	Өөрчлөн найруулсан	1. Бичгээр хадгаламжийн гэрээг байгуулахад заавал хадгаламжийн дэвтэр олгох шаардлага үүсдэггүй, хадгалуулагч хүссэн тохиолдолд хадгаламжийн дэвтэр олгодог. 2. Бичгээр хийх хэлцэл нь цаасан болон цахим хэлбэрээр хийгдэх боломжтой. Иймд найруулгыг засах.

			3. Иргэний хуулийн "42-1.2.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.", "43.2.4. 43.2.4.цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан." гэсэн заалтуудад энэ хуулийн 7.2 заалттай үялдуулан холбогдох өөрчлөлтийг оруулах.
	11.4.Цахим хэлбэрээр байгуулах хадгаламжийн гэрээ нь хадгалуулагч хүсэл зоригоо илэрхийлэн цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг хадгалагч хүлээн зөвшөөрч <u>хуульд заасан хэлбэрээр баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.</u>	Өөрчлөн найруулсан	Хуулийн төслийн 7.2 заалтад нийцүүлэн, " ,тоон гарын үсэг зурж илгээснийг" гэснийг хасах. Цахим гарын үсгийн тухай хууль 2011 онд батлагдсан боловч иргэдийн дунд ойлголт маш хомс, хэрэглээ байхгүй, мөн цахим гарын үсэг авахад үнэтэй, нэвтрүүлсэн технологи нь хэрэглэхэд хүндрэлтэй зэрэг байдал нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд уг хуулийн хэрэгжилт өнөөдрийг хүртэл хангалтгүй байхад нөлөөлж байна. Зөвхөн тоон гарын үсгээс гадна цахим орчинд гэрээ байгуулагч иргэн, хуулийн этгээд хүсэл, зоригоо илэрхийлэх олон боломжууд нэгэнт практикт хэрэглэгдэж байна. Иймд Иргэний хуулийн 42-1.2, 43.2.4 заалтуудад энэ хуулийн төслийн 7.2-той үялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах.
12 дугаар зүйл. Хадгаламжийн гэрээний хугацаа	12.1.Хадгаламжийн гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулна.	Хэвээр үлдээсэн	
	12.2.Тодорхой хугацаа зааж хадгалуулсан хадгаламжийг хугацаатай хадгаламж, тодорхой бус хугацаагаар хадгалуулсан хадгаламжийг хугацаагүй хадгаламж гэж тус тус тооцно.	Хэвээр үлдээсэн	
	12.3.Хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол уг хугацаа дууссаны дараа хадгалагч нь хадгалуулагчийн анхны шаардлагаар мөнгийг буцаан өгч, хүү төлөх үүрэгтэй.	хэвээр үлдээсэн	
	<u>12.4.Банк, эрх бүхий хуулийн этгээд хугацаагүй хадгаламжийн гэрээг зөвхөн иргэнтэй байгуулна.</u>	Шинээр нэмсэн	Энэхүү нарийвчлан зохицуулсан заалт нь төслийн 5.1.3 болон 10.1 дэх хэсэгтэй нийцэж байгаа эсэх. Дээрх 2 зохицуулалт иргэн хуулийн этгээд хугацаатай болон хугацаагүй хадгаламжтай байж болохоор харагдаж байна. Энэ заалтыг 12.2 заалтын дараа, 12.3 заалт болгон оруулах нь логик дарааллын хувьд оновчтой байна.

	12.5.Гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан авах тухай, эсхүл гэрээг дахин сунгуулах шаардлага тавиагүй бол уг хадгаламжийг хугацаагүй хадгаламжид тооцож, хүүг хугацаагүй хадгаламжийн адил хэмжээгээр бодно. Хэрэв хадгаламжийн гэрээнд заасан бол хугацаатай хадгаламжийн хугацаа дууссан тохиолдолд уг гэрээний хугацааг тодорхой хугацаагаар сунгаж болно.	Хэвээр үлдээсэн	Төслийн 12.4 заалттай зөрчилтэй буюу хуулийн этгээдийн хувьд хугацаатай хадгаламжийн хугацаа дуусахад хугацаагүй хадгаламжид тооцож болохоор байна.
	12.6.Тодорхой хугацаагаар байгуулсан хадгаламжийн гэрээг хадгалагч нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас өмнө цуцлах эрхгүй.	Хэвээр үлдээсэн	Нэгээс дээш жил, урт хугацаагаар байгуулсан хадгаламжийн гэрээний хувьд гэрээнд заасан хадгаламжийн хүүг хадгаламжийн гэрээнд заасны дагуу тодорхой давтамжтай Банк хянаж, өөрчлөх эрхтэй байхаар зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, зах зээлийн хүүтэй уялдуулан хадгаламжийн хүүг өөрчлөх боломжтой бөгөөд зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх хүрээнд энэ нь ач холбогдолтой. Энэхүү хадгаламжийн хүүгийн хэмжээг хянаж, өөрчлөх гэрээний нөхцөл нь энэ заалттай зөрчилдөхгүй гэж ойлгож байна.
	12.7.Хадгаламжийн гэрээний хугацааг дансанд орлогын гүйлгээ хийгдсэн өдрөөс эхлэн тоолж, зарлагын гүйлгээ хийгдсэн өдрөөр дуусгавар болгоно.	Хэвээр үлдээсэн	"Хугацаатай хадгаламжийн хугацааг дансанд орлогын гүйлгээ хийгдсэн өдрөөс эхлэн тоолж, зарлагын гүйлгээ хийгдсэн өдрөөр дуусгавар болгоно." гэж өөрчлөх саналтай байна.
	12.8.Хугацаатай хадгаламжийн гэрээг тохиролцсон хугацаанаас өмнө хадгалуулагчийн хүсэлтээр цуцлахад хадгалуулсан хугацаанаас нь хамааруулан хадгаламжийн хүүг гэрээнд заасан хэмжээгээр бууруулж болно.	Хэвээр үлдээсэн	
	12.9.Хадгалуулагч нь хадгалагчаас энэ зүйлийн 12.3, 12.6 дахь хэсэгт заасан үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирол болон гэрээнд заасан бол анз төлүүлэхээр шаардах эрхтэй.	Хэвээр үлдээсэн	

	<u>12.10.Хадгалуулагч нь хадгаламжийн гэрээг цуцлах, хадгаламжаас зарлагын гүйлгээ хийх тохиолдолд хадгалагчид урьдчилан мэдэгдэнэ. Ийнхүү урьдчилан мэдэгдэх доод хугацааг хадгаламжийн гэрээнд тусгах бөгөөд энэ хугацаа нь 3 хоногоос ихгүй байна.</u>	Шинээр нэмсэн	1. "Хугацаагүй" хадгаламжийг хадгалуулагчийн анхны шаардлагаар өгөх үүргийг банк, эрх бүхий этгээд нэгэнт хүлээж байгаа тул энэ зохицуулалт зөвхөн хугацаатай хадгаламжид хамааралтай гэж ойлгож байна. Иймд "...хугацаатай хадгаламжийн гэрээг цуцлах, хугацаатай хадгаламжаас зарлагын гүйлгээ хийх тохиолдолд..." гэх.
			2. Одоогийн нөхцөлийг өөрчлөх хэрэгцээ, шаардлага үүссэн эсэх нь тодорхой бус байна. Ихэвчлэн томоохон үнийн дүнтэй хадгаламжид хамаарах зохицуулалт байх тул шаардлагатай бол "... <u>үнийн дүнгийн доод хэмжээ</u> , хугацааг..." гэх.
	<u>12.11.Хадгаламжийн дансыг төлбөрийн дансны зориулалтаар ашиглахгүй бөгөөд аливаа төлбөрийн хэрэгсэлтэй холбохыг хориглоно.</u>	Шинээр нэмсэн	Төлбөрийн хэрэгсэл гэдэгт ҮТСтХ-ийн "5.1.23. бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт, цахим мөнгө зэрэг Монголбанкны зөвшөөрөл бүхий биет, биет бус хэрэгслийг" ойлгох эсэх.
13 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн хүү	13.1.Хадгаламж хүүтэй байна.	Хэвээр үлдээсэн	
	13.2.Хугацаатай хадгаламжийн хүүгийн хэмжээ нь <u>гэрээнд өөрөөр заасан эсхүл хадгалуулагчаас хадгаламжийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан, хадгаламжийн данснаас хуульд заасан үндэслэлээр зарлагын гүйлгээ хийснээс бусад тохиолдолд</u> анх тохиролцсон хэвээр байна.	Өөрчлөн найруулсан	
	<u>13.3.Хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд хугацаатай хадгаламжид орлогын гүйлгээ хийсэн тохиолдолд хүүг уг гэрээний дагуу хэвээр мөрдөнө.</u>	Өөрчлөн найруулсан	"...тохиолдолд хүүг..." гэснийг "...тохиолдолд хүүгийн хэмжээг..." гэх. Төсөлд хэрэглэсэн хүүгийн хэмжээ, хүү зэргийг нэгдсэн байдлаар хэрэглэх. Хүүгийн хэмжээ гэж хүүгийн хувь хэмжээг, Хүү гэж бодогдсон хүү буюу үнийн дүнг ойлгох гэх мэт.
	<u>13.4.Хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгалагчаас өөрчлөх тохиолдолд энэ тухай нийтэд 1 сарын өмнө мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойшхи хугацаанд хийсэн аливаа орлогын хувьд хадгалагчаас өөрчлөн тогтоосон хэмжээгээр хүүг тооцно.</u>	Өөрчлөн найруулсан	1."1 сар" гэснийг "30 хоног", "тооцно." гэснийг "тооцож болно." гэх. Банк, эрх бүхий этгээд нь шинээр нээсэн хадгаламж болон хугацаатай хадгаламжийн гэрээтэй хадгалуулагч нэмж орлого хийхэд 30 хүртэлх хоногийн хугацаанд шинэ хүүг мөрдөх эсэхийг өөрсдөө системийн боломжоос шалтгаалан, аль хүүгийн хэмжээг баримтлахыг өөрсдөө шийдэх боломжтой байхаар зохицуулах.

			2. Хадгалуулагчийн эрх, ашгийг хамгаалах үүднээс хугацаатай хадгаламжийн гэрээнд хүүг өөрчлөх зохицуулалтад тодорхой хязгаарлалт тавих эсэх, тухайлбал, 12 сараас дээш хугацаатай хадгаламжийн хувьд хүүгийн хэмжээг өөрчлөх боломжтой байх гэх мэт.
	<u>13.5.Энэ хуулийн 13.4-т заасны дагуу өөрчлөлт орсон хүүгийн хэмжээг хадгалуулагч зөвшөөрөхгүй бол нэмж хийсэн орлогын хувьд хадгалуулахаас татгалзаж болно.</u>	Шинээр нэмсэн	Зарим банкны хувьд төлөвлөгөөт буюу тогтмол орлого хийдэг, ийнхүү тогтмол орлого хийснээр хугацааны эцэст нэмэлт хүү, урамшуулал тооцож, хадгалуулагчид олгодог хадгаламжийн бүтээгдэхүүнүүд бий. Энэ заалт хуулинд нэмэгдсэнээр хадгалуулагчаас хамаарсан бус, банкнаас хамаарсан шалтгаанаар хадгалуулагч гэрээний нөхцөлийг хангахгүй буюу орлого хийхгүй болсон тохиолдолд, хадгалуулагчийг хамгаалах нөхцөл үүсэх эсэх. Хэрэв "тийм" бол "Хадгалуулагч ийнхүү татгалзсан нь хадгаламжийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэх үндэслэл болохгүй." гэсэн зохицуулалт нэмэх. Хэрэв "үгүй" бол хадгалуулагч орлого нэмж хийх эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой тул энэ заалтыг нэмэх шаардлага харагдахгүй байна.
	<u>13.6.Хугацаагүй хадгаламжийн дансанд орлогын гүйлгээ хийх, данс хаахаас бусад аливаа гүйлгээ хийх тохиолдолд гэрээнд заасны дагуу хүүг бууруулж болно. Дансыг хааснаар хугацаагүй хадгаламжийн гэрээ дуусгавар болно.</u>	Шинээр нэмсэн	Гэрээний 13.4 заалттай хэрхэн уялдах. Энэ заалт нь ямар агуулгаар хүүг бууруулах үндэслэл болоод байгаа нь ойлгомжгүй байна. Хугацаагүй хадгаламж нь орлого, зарлагын гүйлгээ чөлөөтэй хийх боломжтой, хүүгийн хэмжээ бага байдаг хадгаламж. Хүү нь гэрээгээр зохицуулагдаж, түүнд өөрчлөлт орох тохиолдолд 13.4 заалт мөрдөгдөх учиртай. Иймд энэ заалтын эхний өгүүлбэрийг дахин хянах, эсхүл хасах.
	13.7.Хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк тогтооно.	Хэвээр үлдээсэн	"Хадгаламжийн хүүгийн хэмжээг" гэснийг "Хадгаламжийн хүүг бодох аргачлалыг Монголбанк тогтооно." гэх. "Хадгаламжийн хүүгийн хэмжээ" гэхээр хүүгийн хувь хэмжээ буюу Хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг тогтоох аргачлалыг Монголбанк тогтоох гэж буруу ойлгогдохоор байна.
14 дүгээр зүйл. Хадгалуулагч, хадгалагчийн эрх, үүрэг	14.1.Хадгалуулагч дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 14.1.1.хадгалуулсан мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах хэлбэрийг сонгох; 14.1.2.хадгалуулсан мөнгөн хөрөнгөндөө хүүгийн орлого авах;	Өөрчлөн найруулсан	1. 14.1.4 заалтыг өмнөх хуулийн заалтаар хэвээр үлдээх. Өөрөөр хэлбэл уг заалт хугацаатай хадгаламжийн хувьд хэрэгжих боломжтой. "14.1.4. <u>хугацаатай хадгаламжаас</u> гэрээнд заасан хугацааны дотор зарлагын гүйлгээ хийхгүй байх, зайлшгүй тохиолдолд гүйлгээ хийхээр бол хүсэлтийг бичгээр гаргаж, гэрээнд өөрчлөлт оруулахаар хадгалагчтай харилцан тохиролцох;" гэх.

14.1.3.хадгаламжийн гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулга болон болон холбогдох бусад баримттай тулган шалгах; 14.1.4.хадгаламжаас гэрээнд заасан хугацааны дотор зарлагын гүйлгээ хийхгүй байх, зайлшгүй тохиолдолд гүйлгээ хийхээр бол хүсэлтийг бичгээр гаргаж, гэрээнд өөрчлөлт оруулахаар хадгалагчтай харилцан тохиролцох; 14.1.5.гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгаламжийг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох; 14.1.6.хадгаламжийг өвлүүлэх, гэрээслэх; 14.1.7.хадгаламжийг бэлэглэх; 14.1.8.хадгалагчаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэх; 14.1.9.хадгаламжийг барьцаалах; <u>14.1.10.хадгалагчаас энэ хуулийн 12.6, 14.2.5, 14.2.6-д заасан үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирол болон гэрээнд заасан бол торгууль, алданги төлүүлэхээр шаардах;</u> 14.1.11.талуудын харилцан тохиролцсон бусад эрх, үүрэг.		2. "14.1.9. хадгаламжийг <u>барьцаалуулах</u>" гэх.
--	--	--

	14.2.Хадгалагч дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 14.2.1.хадгалуулагчийн нэр дээр данс нээж хадгаламжийн дэвтэр эсхүл сертификат зэрэг үнэт цаас олгох; 14.2.2.хадгалуулагчийн хадгаламжаас зөвхөн түүний зөвшөөрөл буюу даалгавраар гүйлгээ хийх; 14.2.3.хадгалуулагчийн тавьсан анхны шаардлагаар гэрээнд заасан нөхцөлийн дагуу түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх; 14.2.4.хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох; 14.2.5.Хадгалуулагч болон гүравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад аливаа хэлбэрээр гаргаж өгөх, задруулах, ашиглахгүй байх; <u>14.2.6.харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах;</u> 14.2.7.өөрийн бүрүүгаас учруулсан хохирлыг нөхөн төлөх; 14.2.8.хууль, гэрээнд заасан бусад эрх, үүрэг.	Өөрчлөн найруулсан	"14.2.6. харилцагчийн..." гэснийг "14.2.6. хадгалуулагчийн..." гэх
	14.3.Хадгалагч нь хадгаламжид авсан мөнгөн хөрөнгийг өөрийн гүйлгээнд хэрэглэн түүний бүрэн бүтэн байдлыг хангана.	Хэвээр үлдээсэн	
15 дугаар зүйл. Хадгаламжийн данс	15.1.Хадгалагч нь хадгалуулагч тус бүрт хадгаламжийн данс нээнэ. 15.2.Хадгалуулагч нь хадгаламжийн сертификат зэрэг үнэт цаас авсан бол данс нээхгүй байж болно.	Өөрчлөн найруулсан	
		Хасагдсан	Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Банкны тухай хуульд нийцүүлэн одоо мөрдөгдөж байгаа хуулийн "9 дүгээр зүйл. Мөнгөн хадгаламжийн баталгаа" заалтыг өөрчлөн найруулж оруулах

16 дугаар зүйл. Хадгаламжид холбогдох гүйлгээний талаархи зохицуулалт	16.1.Хадгалуулагч нь хадгаламжийн орлого, зарлагын гүйлгээг бичгээр олгосон итгэмжлэл бүхий төлөөлөгчөөр дамжуулан хийлгэж болно. Хадгалагч хуульд заасан шаардлага хангасан хүчин төгөлдөр итгэмжлэл, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хуульд заасан (Иргэний үнэмлэх) бичиг баримтыг үндэслэн гүйлгээ хийнэ.	Өөрчлөн найруулсан, агуулга ижил	
	16.2.Хадгалуулагч нас барсан болон нас барсан гэж зарлагдсан тохиолдолд хадгалагч хадгаламжийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлах эрх бүхий этгээдэд олгох, эсхүл тухайн хадгаламжийн гэрээг түүний нэр дээр шинэчлэн хийж болно.	Хэвээр үлдээсэн	
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ШИЛЖҮҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА		Өөрчлөн найруулсан	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГЭХ
17 дугаар зүйл.Шилжүүлэг гүйцэтгэх	<u>17.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд (Цаашид “Харилцагч” гэх)-тэй байгуулсан гэрээ, түүний даалгавар, зөвшөөрлийг үндсэлэн шилжүүлгийг гүйцэтгэнэ.</u>	Өөрчлөн найруулан	1. ҮТСтХ-д "5.1.16. төлбөрийн үйлчилгээ", "5.1.18. шилжүүлэг", "5.1.19. кредит шилжүүлэг", "5.1.20. дебит шилжүүлэг", "5.1.21. мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг", "5.1.22. мөнгөн гуйвуулга", "Наймдугаар бүлэг. Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг, цахим мөнгө" гэсэн мөнгөн хөрөнгийн шилжүүлэгтэй холбоотой зохицуулалтуудыг тусгасан байх бөгөөд төсөлд зааснаар энэхүү хуулиар "мөнгөн хөрөнгийн шилжүүлэг" буюу "шилжүүлэг"-ийн үйл ажиллагаанд ҮТСтХ-ийн "5.1.18. шилжүүлэг гэж аливаа этгээдээс <u>төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр</u> дамжуулан мөнгөн хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагааг" ойлгохоор заасан. Өөрөөр хэлбэл, төлбөрийн үйлчилгээнд хамаарч буй бэлэн мөнгөний орлого, зарлага, төлбөр шилжүүлэх, төлбөрийн хэрэгсэл гаргах, хүлээн авах, цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаа энэ хуулинд хамааралгүй, зөвхөн мөнгөн шилжүүлгийн үйл ажиллагаа хамаарна гэж ойлгогдож байна.
			2. ҮТСтХ-д Банк нь "шууд оролцогч буюу харилцагчийн болон өөрийн, гэрээний үндсэн дээр шууд бус оролцогчийн төлбөр тооцоог хариуцан гүйцэтгэж буй оролцогч" гэж тодорхойлогдсон байх бөгөөд Төлбөрийн хэрэгсэл гаргах, Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэхээс бусад тохиолдолд Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болохгүй, мөн эдгээр үйл ажиллагаа нь мөнгөн шилжүүлгийн үйл ажиллагаанд хамааралгүй байна. Өөрөөр хэлбэл, энэ хуулийн төслийн зохицуулалтаар Шилжүүлгийн үйл ажиллагаа Банкинд хамаарахгүй гэж ойлгож болохоор байна.

		3. Хуулийн төслийг дагалдан зарим хуульд хэрэглэсэн "төлбөр тооцоо" гэснийг "мөнгөн хөрөнгийн шилжүүлэг" болгон шууд өөрчилж байгаа нь хэр оновчтой эсэхийг эргэн дахин хянах шаардлагатай. Тухайлбал, Банкны хуульд заасан "төлбөр, тооцооны үйлчилгээ" гэснийг "мөнгөн хөрөнгийн шилжүүлэг" гэж өөрчилснөөр банкны үзүүлдэг төлбөр тооцооны олон төрлийн үйлчилгээ, үйл ажиллагаа бүрэн зохицуулагдах эсэх, үр дагаврыг зайлшгүй тооцон үзэх шаардлагатай харагдаж байна. Шилжүүлэг гэхээр зөвхөн данснаас бэлэн бусаар бусдын дансанд шилжүүлэг хийх буюу зарлагын гүйлгээ хийх агуулгатай бөгөөд орлого хүлээн авах, бэлэн мөнгөний орлого, зарлага зэрэг үйл ажиллагаа хамаарахгүй гэж ойлгогдохоор байна.
<u>17.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь харилцагчийн шилжүүлгийг гүйцэтгэхдээ үг төлбөрийн баримтын бүрдүүлбэрийг шалгасны үндсэн дээр харилцагчийн мөнгөн хөрөнгийн дүнд багтаан шилжүүлгийг гүйцэтгэнэ.</u>	Өөрчлөн найруулсан	
<u>17.3.Төлбөрийн баримт нь бичгийн болон цахим хэлбэртэй байж болно.</u>	Шинээр нэмсэн	Мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйл ажиллагааг зохицуулж байгаа тул Төлбөрийн баримт гэх нь зөв үү?
<u>17.4.Төлбөрийн баримтын бүрдүүлбэрийг ерөнхий нөхцөлд тусгасан байна.</u>	Өөрчлөн найруулсан	Баримтын бүрдүүлбэрийг Ерөнхий нөхцөлд заах шаардлага юу вэ, Ерөнхий нөхцөлд заах нь оновчтой бус. Шилжүүлгийн гүйлгээг зохицуулж байгаа тохиолдолд мөнгөн хөрөнгө шилжүүлэгч, хүлээн авагчийн нэр, дансны дугаар, гүйлгээний дүн, гүйлгээний утга-энэ нь том, жижиг дүнтэй гүйлгээнээс хамаарч гүйлгээний утгыг заавал шаардах эсэх дээр ялгаатай байж болно. МУТСТХ-ийн дагуу том дүнтэй болон сэжигтэй гүйлгээнд тавих хяналтыг хэрэгжүүлэх шаардлага бий. Баримтын бүрдүүлбэрийг Монголбанк тогтоохоор заасан одоогийн хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь заалтыг хэвээр үлдээж зохицуулах нь илүү оновчтой болов уу. Монголбанк гүйлгээний хэмжээ, төрлөөс хамаарч баримтын бүрдүүлбэрийг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах бүрэн боломжтой.
<u>17.5.Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас ирүүлсэн төлбөрийн гүйлгээг шилжүүлгийг хүлээн авсан дэс дарааллыг баримтлан Монголбанкнаас баталсан журамд заасан хугацаанд төлбөрийн системд дамжуулна.</u>	Өөрчлөн найруулсан, агуулга ижил	1. Энэ хуулиар мөнгөн хөрөнгийг шилжүүлгийн үйл ажиллагааг зохицуулахаар заасан. Төлбөрийн гүйлгээ гэсэн нэр томъёо хэрэглэх эсэх. Хэрэв хэрэглэх бол мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, төлбөрийн гүйлгээний зааг, ялгааг тодорхой тусгах. Төлбөрийн гүйлгээ гэж хэрэглэх тохиолдолд шилжүүлгийн гүйлгээг яах нь тодорхойгүй байна.

		2. ҮТСтХ-ийн 5.1.2-т "төлбөрийн систем" гэж оролцогч хоорондын мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх, түүнтэй холбоотой журам, дүрэм, техник, технологи, програм хангамж, төлбөрийн хэрэгсэл бүхий цогц бүтцийг ойлгоно гэж заасан. Өөрөөр хэлбэл, уг цогц бүтцэд дамжуулна гэсэн агуулгаар зохицуулах боломжтой эсэх.
<u>17.6.Банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх хадгаламж, зээл, төлбөрийн дансны орлого, зарлагын гүйлгээ нь бэлэн болон бэлэн бус хэлбэртэй байж болно.</u>	Өөрчлөн найруулсан, агуулга ижил	Эдгээр гүйлгээг бүгдийг мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн гүйлгээ гэж үзэх эсэх. Заалтыг логик дарааллын хувьд 17.1 дэх заалтын дараа 17.2 дахь заалт болгон оруулах?
<u>17.7.Бэлэн бус мөнгөн хөрөнгийн шилжүүлгийг хуульд заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрсөн биет, биет бус төлбөрийн хэрэгслээр гүйцэтгэж болно.</u>	Өөрчлөн найруулсан, агуулга ижил	Логик дарааллын хувьд 17.1, 17.6 заалтын дараа 17.3 дахь заалт болгон оруулах? (Иргэний хуулийн 445 дугаар зүйлд нийцсэн байдлыг хянан үзэх).
<u>17.8.Төлбөрийн нэхэмжлэлээр хийх төлбөрийг гагцхүү төлбөр хариуцагчийн мөнгөн хөрөнгийг зарцуулах эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Векселиэр хийх шилжүүлгийг Векселийн тухай хуулиар зохицуулна.</u>	Өөрчлөн найруулсан	Мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, төлбөрийн гүйлгээний зааг, ялгааг хуульд тодорхой тусгах.
<u>17.9.Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн шилжүүлгийг залруулж харилцагчийг хохиролгүй болгоно.</u>	Шинээр нэмсэн	1. Мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, төлбөрийн гүйлгээний зааг, ялгааг хуульд тодорхой тусгах. Мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, мөнгөн шилжүүлэг, мөнгөн төлбөрийн шилжүүлэг, төлбөр, төлбөрийн гүйлгээ, орлого зарлагын гүйлгээ зэрэг ялгаатай нэр томъёог хуульд нэг мөр зохицуулах.
		2. "...шилжүүлгийг залруулж..." гэснийг "...нэн даруй залруулж..." гэх, эсхүл хугацааны зохицуулалтыг Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулинд нэг мөр зохицуулах.
<u>17.10.Энэ хуулийн 17.5-д заасан хугацаанд шилжүүлгийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгээгүйгээс үүсэх хохирлыг банк, эрх бүхий хуулийн этгээд хариуцна.</u>	Өөрчлөн найруулсан	Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт юу орох вэ? Логик дарааллын хувьд энэ заалт 17.5 заалтын дараа орох.

	<u>17.11.Данс эзэмшигчийн хүсэлтээр банк, эрх бүхий хуулийн этгээд нь гүйлгээ хийгдсэн дансны хуулгыг данс эзэмшигчид өгнө.</u>	Өөрчлөн найруулсан, агуулга ижил	гүйлгээ хийгдсэн данс гэсэн нь төлбөрийн данс мөн үү? мөн бол ижил нэр томъёо хэрэглэх. Энд хадгаламжийн данс мөн хамаарах эсэх. Хэрэв тийм бол тодорхой заах, энэ заалтыг Хоёрдугаар бүлэг, Хадгаламж, төлбөрийн данс гэсэн бүлэгт шилжүүлж, зохицуулах.
	<u>17.12.Монголбанк мөнгөн хөрөнгийн шилжүүлэгтэй холбогдох харилцааг зохицуулах журам, зааврыг баталж, шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавина.</u>	Шинээр нэмсэн	Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6.3.3-т үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг зохицуулах, шинээр төлбөрийн хэрэгсэл гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах бүрэн эрхийг Монголбанк хэрэгжүүлнэ гэжээ. Уг хуульд зааснаас ялгаатай, тусгайлан журам батлахаар зохицуулсан эсэх, тийм бол энэ заалтыг тодруулах шаардлагатай. “...шийдвэр гаргаж...” гэснийг хасах, эсхүл ямар шийдвэр гаргах гэдгийг тодорхой тусгах
	<u>18.1.Төлбөрийн дансны үлдэгдэлд хүү тооцохгүй.</u>	Шинээр нэмсэн	
18 дугаар зүйл.Төлбөрийн данс, төлбөрийн дансны дэд эзэмшигч	<u>18.2.Төлбөрийн данс нь данс эзэмшигч, дэд данс эзэмшигчтэй байж болно.</u>	Шинээр нэмсэн	Дэд данс эзэмшигч гэсэн нь ойлголтын зөрүү үүсгэхээр байна. Дансны дэд эзэмшигч, эсхүл Хязгаартайгаар данс эзэмших эрхтэй этгээд гэж өөрчлөх саналтай байна. Үгүй бол дансны доор данс байх, тэр нь тусдаа эзэмшигчтэй байх мэт ойлголт төрүүлэхээр байна. Энэ ойлголт, зохицуулалтыг ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАДГАЛАМЖ хэсэгт, хадгаламжийн дансанд нэмэх. Эсхүл хадгаламжийн болон төлбөрийн дансанд адил хэрэглэх боломжтой бол Данс дэд эзэмшигчтэй холбоотой зохицуулалтыг "ХОЁДУГААР БҮЛЭГ. ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨРИЙН ДАНС" хэсэгт шилжүүлж, нэгдсэн байдлаар зохицуулах.
	<u>18.3.Төлбөрийн данс эзэмшигчээс олгосон эрхийн хүрээнд төлбөрийн данснаас данс эзэмшигчийн эрхийг хязгаартайгаар хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг төлбөрийн дансны дэд данс эзэмшигч (цаашид “Дэд эзэмшигч” гэх)гэнэ.</u>	Шинээр нэмсэн	"...төлбөрийн дансны дэд эзэмшигч (цаашид "дэд эзэмшигч" гэх)... " гэж өөрчлөх.

	<u>18.4.Дэд эзэмшигч нь төлбөрийн данс эзэмшигчээс хуульд заасны дагуу олгосон итгэмжлэлийн хүрээнд төлбөрийн данснаас зарцуулалт хийнэ.</u>	Шинээр нэмсэн	Дэд данс, дэд эзэмшигч гэх асуудал нь Иргэний хуульд заасан "итгэмжлэл"-ийн үндсэн дээр төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой харилцаанаас ялгагдах онцлог байгаа эсэх нь тодорхойгүй байна. Нэгэнт Иргэний хуульд зааснаар итгэмжлэлээр данснаас зарцуулалт хийх тохиолдолд "дэд эзэмшигч" гэсэн зохицуулалт байх шаардлага бий эсэх. Дэд данс эзэмшигчтэй холбоотой энэ хуульд заасан харилцаа нь заавал итгэмжлэл шаардахгүйгээр гүйлгээ хийх, захиран зарцуулах харилцааг зохицуулж байгаа гэж ойлгож байна. Иймд энэ зохицуулалтыг эргэж хянах.
	<u>18.5.Дэд эзэмшигчид хуульд заасан төлбөрийн данс эзэмшигчид тавих шаардлагыг нэгэн адил тавина.</u>	Шинээр нэмсэн	Дэд эзэмшигч нь Иргэний хуульд зааснаар итгэмжлэгдсэн төлөөлөгч байх бол тийнхүү төлөөлөх боломжтой этгээд байна гэсэн үг. Тэгэхээр дансыг бусдын өмнөөс удирдахад данс эзэмшигчид тавигдах шаардлагыг бүрэн хангасан байхыг давхар шаардах хэрэгцээ байх эсэх?
19 дүгээр зүйл. Төлбөр хүлээн авагч	19.1.Төлбөр хүлээн авагч нь ажил, үйлчилгээний үнэ, хөлс, нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний үнийг энэ хуулийн 17.4-т заасан төлбөрийн баримтын бүрдүүлбэрийг хангасан баримтын дагуу нэхэмжилнэ.	Хэвээр үлдээсэн	Төлбөр хүлээн авагч гэсэн тодорхойлолт байхгүй. Төлбөрийн данс эзэмшигч нь гэх? Энэ хуулиар зохицуулж буй мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйл ажиллагаанд төлбөр нэхэмжлэгчийн төлбөр хариуцагчаас төлбөр нэхэмжлэх харилцаа хамаарах эсэх?
20 дугаар зүйл. Төлбөр хариуцагч	20.1.Төлбөр хариуцагч гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний болон худалдан авсан бараа, бүтээгдэхүүний үнэ хөлсийг төлөхийг зөвшөөрсөн бол энэ хуулийн 17.4-т заасан төлбөрийн баримтын бүрдүүлбэрийн дагуу төлбөр төлөх үүрэг хүлээнэ.	Хэвээр үлдээсэн	Төлбөр хариуцагч гэсэн нэр томъёоны тодорхойлолт байхгүй. Төлбөр хариуцагчийн төлбөр төлөх харилцаа энэ хуулиар зохицуулж буй мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн үйл ажиллагаанд хамаарах эсэх?
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА		Өөрчлөн найруулсан, агуулга ижил	ТАВДУГААР БҮЛЭГ ГЭХ. Энэ хууль нь бүхэлдээ банк, эрх бүхий этгээдэд хамааралтай тул бусад бүлгийн адил энэ бүлгийн нэрийг ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА гэх эсэх?
21 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа	21.1.Зээлийн харилцаа зээлдүүлэгчээс зээлдэгчид гэрээнд тохиролцсон хэлбэрээр олгосноор эхэлж зээлдэгч зээлдүүлэгчид буцаан төлснөөр дуусгавар болно.	Өөрчлөн найруулсан	1. Хуульд "Зээлдүүлэгч" гэж хэн болох тухай тодорхойлолт өмнө тусгагдаагүй байна. Иймд "Зээлдүүлэгч" гэж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий банк, хуулийн этгээдийг гэсэн тайлбарыг хуулинд тусгах. 2. "...зээлдэгчид..." эсхүл "...хэлбэрээр..." гэсний дараа "зээлийг" гэж нэмэх?
	21.2.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлэх үүрэгтэй.	Өөрчлөн найруулсан	

	21.3.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно.	Хэвээр үлдээсэн	5.1.1-т заалтад тусгасан саналд дурьдсанчлан зээлийн зориулалтыг заавал тусгахаар хуульчлах шаардлагагүй гэж үзэж байна. Зээлийн зориулалтыг заах шаардлагагүй, заасан ч зориулалтаар ашигласан эсэхийг хянах боломжгүй зээлийн бүтээгдэхүүнүүд практикт байдаг.
	21.4.Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийг зээлжих эрх, зээлийн карт, зээлийн шугам зэрэг хэлбэрээр, техникийн хэрэгсэл, програм хангамж ашиглан олгож болно.		1. Энд заалтад дурьдсаныг төслийн 21.1, 21.6-д заасан зээл олгох хэлбэр мөн үү? Стандарт нөхцөлтэй (тодорхой хугацаа, зээлийн хугацаанд хугацааны эцэст болон хэсэгчилж эргэн төлөх нөхцөлтэй) болон бэлэн, бэлэн бусаар, уламжлалт хэлбэрээр олгох зээлийг зээлийн хэлбэр гэж үзэх үү? 2. "...техникийн хэрэгсэл, програм хангамж ашиглан цахимаар олгож болно." гэх. Уламжлалт хэлбэрээр буюу банк, эрх бүхий этгээдийн салбар дээр биеэр очиж олгож буй зээл техник хэрэгсэл ашиглан, програм хангамж дээр бүртгэгдэн олгогддог тул цахимаар гэдгийг тодотгон тусгах.
	21.5.Гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн төлбөрийн дансанд <u>шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцно.</u>	Өөрчлөн найруулсан	Зээлийн эрх, шугам, кредит картын хувьд зээлийн данснаас зээлээ ашигласан гэж үзэх боломжтой. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зориулалтаар зээл олгох тохиолдолд зээлийг бараа, ажил, үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдэд шилжүүлдэг, мөн банкууд зээлдэгч гуравдагч этгээдэд төлбөр гүйцэтгэхэд зориулан зээл олгодог, түүнийг харилцах дансаар дамжуулан олгоход гүйлгээнд хязгаар тавих, гүйлгээг хянах байдлаар, нэмэлт ажиллагаатай зохицуулдаг. Энэ заалтад уг харилцаа багтаж байгаа юу? "...зээлдэгчийн төлбөрийн дансанд шилжүүлсэн..." гэснийг "... зээлдэгчийн эсхүл зээлдэгчийн зөвшөөрсөн төлбөр хүлээн авагчийн төлбөрийн дансанд" гэх зэргээр нэмж тусгах. Төлбөрийн данс гэдэгт төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгө гаргах үйлчилгээ эрхэлж буй банкнаас бусад хуулийн этгээдэд нээсэн цахим хэтэвч, бусад дансыг хамруулан ойлгож байгаа эсэхийг давхар анхаарч үзэх. Энэ төрлийн дансанд зээлийг олгох, шилжүүлэх зайлшгүй шаардлага бий.
	21.6.Зээл олгох хэлбэрийг зээлдэгч, зээлдүүлэгч нь зээлийн гэрээндээ харилцан тохиролцоно.		Зээл олгох хэлбэр гэдгийг юу гэж ойлгож байгаа вэ? 21.4-т заасныг ойлгох үү? Төслийн 21.1-т гэрээнд зээл олгох хэлбэрийг заана гэсэн санаа агуулагдаж байгаа тул энд тусгайлан заах шаардлагатай эсэх.
	<u>21.7.Гадаад валютаар зээл хүссэн зээлдэгчид ханшийн эрсдэлийн талаарх зөвлөмж, мэдээллийг зээлдүүлэгч өгнө.</u>	Шинээр нэмсэн	

	<u>21.8.Зээлийг гэрээнд заасан зориулалтаар нь ашиглана. Олгосон зээлийн ашиглалтыг зээлдүүлэгч шалгаж, зээлдэгч зээлийн зориулалтын дагуу ашиглаагүй, зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож зээлийг буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болсон бол зээлдүүлэгч зээл олгохоос татгалзах, олгосон зээлийг нэн дариу буцаан шаардах эрхтэй.</u>	Өөрчлөн найруулсан	1. "Зээлдэгч зээлийн гэрээнд заасан зориулалтаар нь ашиглана." гэх. 2. Зээлдэгчийн эд хөрөнгө гэдэгт ямар эд хөрөнгийг ойлгож байна вэ? Ерөнхий өргөн агуулгаар орж байна уу? Барьцаалуулан эд хөрөнгө, зээлээр авсан эд хөрөнгө, эсхүл үйл ажиллагаа явуулж буй буюу зээл төлөх орлого олж буй эд хөрөнгө зэргээр олон агуулгатай байж болно. Зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож зээлийг буцаан төлөх чадваргүй болсон гэдгийг тодорхойлох боломжит шалгуурыг тогтоох, эсхүл хэн хэрхэн тогтоох зарчмыг тусгах эсэх. 3. одоо мөрдөж буй хуулийн 26 дугаар заалтаар хэвээр үлдээх. Энэ заалтын 2 дахь хэсгийг тусад нь энэ бүлгийн төгсөлд зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцлах,зээл төлүүлэхтэй ажиллагаатай холбоотой 30 дугаар зүйлд заалт болгон оруулж, одоо мөрдөж буй хуулийн заалтаар хэвээр үлдээх.
	<u>21.9.Зээлдэгч зээлээ төлсөн эсхүл зээлийн гэрээний үүрэг дуусгавар болсон тохиолдолд зээлдүүлэгч зээлдэгчийн зээлийн дансыг хааж, зээлийн барьцаа хөрөнгийг чөлөөлж, энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.</u>	Шинээр нэмсэн	Барьцааны гэрээг Зээлийн гэрээнээс тусдаа, урт хугацаагаар байгуулж, уг Барьцааны гэрээний хүрээнд богино хугацаатай Зээлийн гэрээг байгуулах, олон дахин зээл олгох практик байдаг. Өөрөөр хэлбэл, харилцагч, банк, эрх бүхий байгууллагад үүсэх ажиллагааг багасгах, харилцагчаас гарах зардлыг бууруулах боломж бүрддэг. Иймд энэ заалтад тусгасан зээлээ төлсөн, зээлийн гэрээний үүрэг дуусгавар болох тухай бүрт барьцаа хөрөнгийг чөлөөлөх хатуу нөхцөлийг өөрчилж, дээрх уян хатан байх нөхцөл, боломжийг тусгах. Эсхүл, холбогдох харилцааг Иргэний хуулиар зохицуулж, энэ заалтыг хасах.
	<u>21.10.Банкнаас олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой журмыг Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой журмыг Санхүүгийн зохицуулах хороо тус тус баталж, хэрэгжилтэд хяналт тавина.</u>	Шинээр нэмсэн	Энэ заалт хэрэгжих боломжтой эсэх. Өөрөөр хэлбэл, барьцаа хөрөнгийн үнэлгээний асуудлыг зохицуулагч байгууллага зохицуулах боломжтой эсэх.Одоогоор энэ зохицуулалт байдаггүй.
	<u>21.11.Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбоотой журмыг Монголбанкнаас баталж, хэрэгжилтэд хяналт тавина.</u>	Шинээр нэмсэн	
	<u>21.12.Гадаад валютын эх үүсвэртэй этгээдэд гадаад валютын зээл олгоно.</u>	Шинээр нэмсэн	1. ТТҮМТГТХ-ийн 4.4.Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгслэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно. гэсэнтэй зөрчилдөх эсэх.

			2. Гадаад валютын эх үүсвэртэй этгээдэд зөвхөн гадаад валютын зээл олгох мэтээр ойлгогдохоор байна. "Гадаад валютаар олгох зээлийг зөвхөн гадаад валютын эх үүсвэртэй тохиолдолд олгоно" гэх мэтээр найруулгыг засах.
			3. Гадаад валютын эх үүсвэр гэдэгт юуг ойлгох вэ? Орлогоос гадна зээл, хөрөнгө оруулалт зэрэг багтах эсэх?
22 дугаар зүйл.Зээлийн гэрээ	22.1.Иргэний хүүлийн 451.1-д заасны дагуу банк, эрх бүхий хүүлийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, эрх бүхий хүүлийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.	Хэвээр үлдээсэн	
	22.2.Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна: 22.2.1.зээлийн хэмжээ; 22.2.2.валютын төрөл; 22.2.3.зээлийн дансны дугаар; 22.2.4.зээлийн зориулалт; 22.2.5.зээлийн гэрээний хугацаа; 22.2.6.зээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл; 22.2.7.зээлийн хүүгийн хэмжээ; 22.2.8.зээлийн гэрээнд оролцогч талуудын оршин байгаа, оршин суугаа газрын хаяг; 22.2.9.гэрээгээр тохиролцсон бол үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэлбэр; 22.2.10.гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээг цуцлах нөхцөл; 22.2.11.хуулиар хориглоогүй шаардлагатай бусад.	Өөрчлөн найруулсан. Агуулгын хувьд өөрчлөлтгүй	1. Хуулийн төслийн 21.4-т заасан зээлийн шугам, зээлжих эрх зэргийн хүрээнд одоо хэрэгжиж буй хуулийн хүрээнд нэг удаа бичээр гэрээ байгуулж, олон давтамжтай, олон зориулалтаар, зээл бүр ялгаатай хэмжээ, хугацаа, нөхцөлтэй олгогдох боломжтой. Өөрөөр хэлбэл, зээлийн хэмжээ, зээлийн зориулалт, зээл төлөх нөхцөл, зээлийн хүү, хураамж, шимтгэлийн нөхцөл зэрэг нь тухай бүр олгох зээлд ялгаатай, өөр байх боломжтой байдаг. Энэхүү заалт нь эдгээр боломж, нөхцөлийг хаагаагүй гэж ойлгож байна.
			2. "22.2.3. Зээлийн дансны дугаар;" гэснийг хасах; 3. "22.2.4. Зээлийн зориулалт;" гэснийг хасах. Зээлийн зориулалтыг гэрээнд заавал тусгах заалт болгон оруулахыг шаардахгүй байх. Өмнө дурьдсанчлан олон зориулалтаар зээлийг олгож болно, мөн зарим төрлийн зээлд зориулалтыг заасан ч ашиглалтыг хянах шаардлагагүй, эсхүл боломжгүй байдаг. Хуулийн төслийн 21.8-д зээлдэгч зээлийг зориулалтаар ашиглаагүй тохиолдолд хүлээх хариуцлага буюу банк, эрх бүхий этгээдийн эрх ашгийг хамгаалах заалт тусгагдсан бөгөөд банк, эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл зээлийн зориулалтыг зээлийн гэрээнд тусгаж болно.

			4. "22.2.5. Зээлийн гэрээний хугацаа;" гэснийг хасах. Нэг зээлийн гэрээгээр олон дахин давтан зээл олгох нөхцөлтэй, эсхүл зээлийн шугам, зээлжих эрхийн гэрээг, түүнийг цуцлах, дуусгавар болгох нөхцөл бүрдэх хүртэл хүчин төгөлдөр мөрдөхөөр байгуулах боломжтой. Өөрөөр хэлбэл, 22.2.10 заалтаар зээлийн гэрээнд зээлийн гэрээг дуусгавар болгох, цуцлах нөхцөл нэгэнт мөрдөгдөх тул 22.2.5-д заасныг хасах.
			5. "22.2.7. Зээлийн хүүгийн хэмжээ;" гэснийг "22.2.7. Зээлийн хүү, хураамж, шимтгэлийн нөхцөл;" гэх.
	22.3.Гэрээнд заасан бол зээлдэгч нь зээлийн гэрээний хугацаа дуусахаас өмнө зээлийг түүний хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хамт буцаан дуудах эрхтэй бөгөөд ийнхүү буцаан дуудсанаар зээлийн гэрээний хугацаа дуусгавар бол тооцно.	Шинээр нэмсэн	1. "...зээлдэгч..." гэснийг "...зээлдүүлэгч..." гэх?
			2. "буцаан дуудах" гэж юуг ойлгох, энэ тухай хуулийн нэр томъёо Иргэний хууль болон бусад хуульд байхгүй. Энэ заальнь хуулийн төслийн 21.8-д заасан зээлийг буцаан төлөх чадваргүй болсон тохиолдолд нэн даруй буцаан шаардах гэсэнтэй адил үр дагавартай байхаар байна. Гэрээнд заасан аливаа шалтгаанаар зээлийг буцаан дуудахаар зохицуулах нь Иргэний хуульд заасан Гэрээний стандарт нөхцөлд тавигдах шаардлагатай зөрчилдөх боломжтой. Иймд энэхүү заалтыг 21.8-ийн 2 дахь хэсэгтэй нэгтгэж, үндэслэл, шалтгааныг бодитой, тодорхой болгон, энэ бүлгийн төгсөлд зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцлах, зээл төлүүлэх ажиллагаатай холбоотой 30 дугаар зүйлд заалт болгон оруулах нь оновчтой гэж үзэж байна. (21.8-д өгсөн 3 дахь саналтай танилцана уу)
	22.4.Зээлийн гэрээний хугацаа дууссан нь гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.	Хэвээр үлдээсэн	"...зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс... гэснийг "...зээлийн гэрээгээр хүлээсэн зээлийн мөнгөн төлбөрийн үүргээс...", эсхүл "...зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүү, бусад төлбөрийн үүргээс..." гэх.
	<u>22.5.Гэрээнд заасны дагуу зээлийн төлбөрийг бүхэлд нь буцаан дуудах нөхцөл байдал үүссэн нь зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.</u>	Шинээр нэмсэн	Олон улсад хэдийнээ дэлгэрсэн, Монгол Улсад нэвтэрч буй кредит карт, худалдан авалтын дараа төлбөрт зээл зэрэг шинэ төрлийн үйлчилгээний хувьд хүү, нэмэгдүүлсэн хүүгээс гадна бусад төлбөр, шимтгэлийн үүргүүдийг гэрээгээр хүлээлгэж байгаа. Иймд "зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс..." гэснийг " <u>...зээлийн гэрээгээр хүлээсэн зээлийн мөнгөн төлбөрийн үүргээс...</u> ", эсхүл " <u>...зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүү, бусад төлбөрийн үүргээс...</u> " гэх.

	22.6.Тодорхой төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр олгох зээлийн эх үүсвэрийг зээлдүүлэгчид хамтарч гаргаж болно. Хамтарч зээл олгохдоо энэ талаар гэрээ байгуулна.	Хэвээр үлдээсэн	
	22.7.Засгийн газрын мэдлийн гадаад эх үүсвэр, олон улсын байгууллагын хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэх зээлийн харилцааг зээлдэгч болон Засгийн газар, төлбөр тооцоог гүйцэтгэгч банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.	Хэвээр үлдээсэн	Төлбөр тооцоо гэснийг мөнгөн хөрөнгийн шилжүүлэг болгон өөрчлөхөөр хуулийн төсөлд заасан. Гэхдээ энэ хуулийг дагалдан гарах төлбөр тооцоо гэснийг мөнгөн шилжүүлэг болгон өөрчлөх тухай хуулиудын төслийг нэг бүрчлэн дахин хянаж үзэх, үр дагаврыг тооцон үзэх шаардлагатай харагдаж байна. Зарим этгээдэд мөнгөн шилжүүлгээс гадна төлбөр тооцооны үүрэг нь хадгалагдах шаардлагатай.
	<u>22.8.Зээлийн гэрээнд зээлдэгчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээдийг хамтран зээлдэгч гэнэ.</u>	Шинээр нэмсэн	Хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийг зээлийн гэрээнд тусгах, зээлдэгчтэй хамт эрх, үүрэг хүлээн гарын үсэг зурах зохицуулалтыг хуульд нэмж тусгах эсэх.
	<u>22.9.Зээлийн гэрээнд зааснаар гэрээний үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээх үүрэг бүхий этгээдийг хамтран үүрэг гүйцэтгэгч гэнэ.</u>	Шинээр нэмсэн	
23 дугаар зүйл.Зээлийн хүү	<u>23.1.Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно.</u>	Шинээр нэмсэн	Иргэний хуулийн "452.1.Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно." гэсэнтэй ижил, давхардсан заалт тул энэ хуульд давхардуулан оруулах шаардлагатай эсэх.

	23.2.Зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцсон зээлдэгчийн хариу төлбөр нь зээлийн хүү болно.	Өөрчлөн найруулсан	Хуулийн төслийн үзэл баримтлалд санхүүгийн салбарын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ өөрчлөгдөн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор уг хуулийг шинэчлэн найруулж банк, эрх бүхий хуулийн этгээдийн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай гэжээ. Мөн Иргэний хуулийн 452.1-т Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно гэж заасан. Хүүгүй зээлд зээлийн үйлчилгээний хариу төлбөрт шимтгэл, хураамж зэрэг бусад хэлбэрийн төлбөр авах нөхцөлийг хуулиар нээлттэй болгон зохицуулах. Цахим хэлбэрээр олгож буй бичил зээлийн төлбөрийг харилцагчид нээлттэй, ил тод, энгийн, ойлгомжтой байлгах, олон төрлийн төлбөр, тухайлбал хүү, хураамж, шимтгэл зэргийг нэгэн зэрэг авахаас зайлсхийж, нэг төрлийн төлбөрт багтаан шийдвэрлэх нь илүү оновчтой байдаг. Зээлийн хүү, хураамж, шимтгэл, бусад төлбөрийн харилцаа нь Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулинд мөнгө хүүлэлтийн талаарх зохицуулалтад нийцэх бүрэн боломжтой.
	23.3.Зээлийн хүүг зээлийг ашигласан хугацаагаар тооцно.	Хэвээр үлдсэн	
	23.4.Зээлдэгч нь зээлийг заасан хугацаанд төлөөгүй бол зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах, <u>эсхүл зээлийн гэрээг цуцлах хүртэл хугацаанд зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлнө.</u>	Өөрчлөн найруулсан, Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг гэрээгээр тохирч болохоор заасан.	Иргэний хуулийн "453.1. Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй" гэж заасанд нийцэж буй эсэх. 23.5 заалтад өгсөн хэтэрсэн хугацааны хүүний талаар зохицуулалтыг өөрчлөх саналыг харна уу.
	<u>23.5.Зээлийн гэрээг цуцалсанаас хойш зээлийн мөнгөн төлбөрийн үүргийг бүрэн гүйцэтгэх хүртэл хугацаанд хэтэрсэн хугацааны хүүг Монголбанкны бодлогын хүүгийн хэмжээгээр тооцож төлнө.</u>	Шинээр нэмсэн, Нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээг МБ-ны хүүгийн хэмжээтэй уялдаатай байх ёстой.	1. Энэ заалтаар шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг (зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй) зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд мөнгө бодитоор төлөгдөх хүртэл энд заасан хэмжээгээр хүү тооцогдоно гэсэн нэмэлт нөхцөл гэж ойлгож байна. Зээлийн гэрээг цуцлахгүй, зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсны дараа шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд энэ зохицуулалт мөрдөгдөх үү? "Зээлийн гэрээг цуцалсан өдрөөс хойш" гэдэгт "зээлийн гэрээний хугацаа дуусгавар болсон" нөхцөлийг агуулах уу? Зээлийн гэрээг цуцлах, дуусгавар болох 2 нөхцөл тусдаа, зээлийн гэрээг дуусгавар болох нөхцөл нь зээлийн гэрээг цуцлах нөхцөлийг агуулдаг. Энэ заалтыг " <u>зээлийн гэрээг дуусгавар болсон өдрөөс хойш...</u> " гэж өөрчлөх.

			2. Иргэний хуулийн "453.1. Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй" гэж заасан. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн энэ заалтаар зээлийн гэрээг цуцалсан эсэхээс үл хамаарч, зээлийн гэрээний хугацаанд зээлийн төлбөр хугацаа хэтэрсэн бол хэтэрсэн хугацааны хүү буюу хуулийн төслийн энэ заалтаар Монголбанкны бодлогын хүүгээр хүүг тооцохоор зохицуулагдаж байна. Мөн энд тодорхойлсон зээлийн гэрээний үндсэн хүүгээс ялгаатай хүүг зээлийн нийт үлдэгдэлд тооцох эсэх, эсхүл хугацаа хэтэрсэн төлбөрийн дүнд тооцох эсэх нь тодорхойгүй байна. Иймд төслийн энэ заалтад заасан <u>"хэтэрсэн хугацааны хүүг зээлийн гэрээний хугацаанд гэрээнд заасан үндсэн хүү, зээлийн гэрээ цуцлагдсан, дуусгавар болсноос хойш Монголбанкны бодлогын хүүгийн хэмжээгээр тооцож төлөхөөр"</u> зохицуулалтыг өөрчлөх.
			3. Иргэний хуулийн 452.2, 453.1 болон хуулийн төслийн 23.4-т заасны дагуу гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлүүлэх боломжтой. Нэмэгдүүлсэн хүүг энэ заалт хэрэгжих тохиолдолд аль хувиас тооцох вэ? ИХ-ийн 452.2-ийн дагуу зээлийн гэрээнд заасан үндсэн хүүгээс нэмэгдүүлсэн хүүг тооцно гэж үзэх үү?
	23.6.Зээлийн хүүгийн хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална.	Хэвээр үлдсэн	Одоогийн Монголбанкнаас баталсан аргачлал нь Банкуудад мөрдөх "Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын хавсралтаар батлагдсан. Иймд журмын хавсралтаар батлагдсан аргачлалыг журмаас салган, тусад нь баримт бичиг болгож батлах, уг аргачлалыг энэ хуульд заасны дагуу Банк, эрх бүхий этгээдэд мөрдөхөөр зохицуулах нь оновчтой байна.
24 дүгээр зүйл.Зээлийн хувийн хэрэг	24.1.Зээлдүүлэгч нь зээлдэгч бүрийн нэр дээр зээлийн хувийн хэрэг нээж хөтөлнө.		Цахим сувгаар олгох зээлтэй холбоотой баримт, мэдээлэл нь цахим хэлбэрээр хадгалагддаг, зээлдэгч бүр дээр хувийн хэрэг гэж тусад нь үүсгэх шаардлага байдаггүйг харгалзан үзэх. Хувийн хэрэгтэй байх зорилго, ач холбогдлыг хангасан бол заавал хэлбэрийн шаардлага тавихгүй байх.

	24.2.Зээлийн хувийн хэрэг дараахь бүрдүүлбэртэй байна: 24.2.1.зээл олгохыг хүссэн өргөдөл; 24.2.2.зээлийн гэрээ; <u>24.2.3.зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахаар сонгосон арга хэлбэр, түүнтэй холбогдох мэдээлэл;</u> <u>24.2.4.иргэн бол орлогын талаархи мэдээлэл;</u> <u>24.2.5.хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд бол санхүүгийн тайлан;</u> <u>24.2.6.зээл хүсэгчийн өр, орлогын харьцааг нотолсон баримт бичиг;</u> 24.2.7.зээлийн ашиглалт шалгасан материал; 24.2.8.зээлдэгчийн бусад банкнаас авсан зээл, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн мөнгөн төлбөрийн үүргийн талаарх зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл; 24.2.9.зээлдүүлэгчээс зээл олгоход шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл, баримт бичиг.	Өөрчлөн найруулсан	Зээлийн төрөл, онцлогоос хамаарч зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэр ялгаатай байх боломжтой. Иймд хуулинд зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг нэг бүрчлэн заахгүйгээр зохицуулагч байгууллага, Монголбанк, СЗХ-ноос баталсан журмаар зохицуулахаар өөрчлөх.
	24.3.Зээлийн үүргийн гүйцэтгэлд барьцаалах эд хөрөнгийн тодорхойлолтод иргэн, хуулийн этгээд, <u>Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдээс</u> барьцаалж байгаа эд хөрөнгийг зээлдүүлэгч банк, эрх бүхий хуулийн этгээдээс газар дээр нь очиж, нэг бүрчлэн үзэж өгсөн үнэлэлт, дүнг тусгасан байна. Зээлийн үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгийг шалгасан баримтад дээрх тодорхойлолтыг үндэслэн үг хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үнэ, чанар зэргийг бичнэ.	Өөрчлөн найруулсан, МУ-н хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд хөрөнгө барьцаалж болох тухай тусгасан.	1. Энэ зохицуулалтыг Монголбанк, СЗХ-ны холбогдох журмаар зохицуулах нь оновчтой байна. Зээлийн хэмжээ, барьцаалуулсан биет болон биет бус эд хөрөнгө, эрхийн төрөл, үнэлгээ зэргээс хамаарч тавигдах шаардлага ялгаатай байх боломжтой. Мөн цахим шилжилт хийгдэж байгаа өнөө үед заавал газар дээр очиж, нэг бүрчлэн үзэх шаардлага байхгүй, цахим хэлбэрээр улсын бүртгэл, бусад мэдээлэл дээр үндэслэн баталгаажуулах, зарим хөрөнгийн хувьд банк, эрх бүхий этгээд өөрөө тогтоосон жишиг үнэ зэргийг баримтлах, зээлийн эрсдэлээс хамгаалах үүднээс дотоод журмаараа зохицуулах бүрэн боломжтой бөгөөд Монголбанк, СЗХ-ны журамд банк, эрх бүхий этгээдийн дотоод журамд барьцаа хөрөнгийн баталгаажуулалт, хяналт, үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгах шаардлагыг тусгаж болно. 2. Зээлийн хувийн хэрэгт зээлийн барьцаатай холбоотой зохицуулалт байхгүй, мөн зээлийн хувийн хэргийг нэг бүрчлэн хуульд заах шаардлагагүй тул энэ заалтыг хасах, эсхүл Монголбанк, СЗХ-ны журмаар зохицуулна гэсэн дээр дурьдсан агуулгаар хуулийн 26.2 дахь заалт болгон оруулах.

	24.4.Зээлийн <u>баталгаа гаргагч, батлан даагчийн бүртгэлд баталгаа гарагч, батлан даагчийн</u> нэр, хаяг, харилцагч банкны нэр, харилцах дансны дугаар зэргийг тусгана. <u>Баталгаа гарагч, батлан даагчийн</u> үйлдвэрлэлийн хүчин чадал, үйл ажиллагааны талаар зээлдэгчийн адил судалж тэмдэглэсэн байна.	Өөрчлөн найруулсан, Баталгаа гаргагч энэ хуулийн дагуух харилцаанд орох боломжтой гэж тусгасан	1. Энэ заалтыг хуулийн 25 дугаар зүйл Батлан даалт хэсэгт шилжүүлэх нь оновчтой байна. Баталгаа, баталгаа гаргагчийн нэр, хаяг, харилцагч банкны нэр, харилцах дансны дугаар зэргийг Баталгааны болон Батлан даалтын гэрээнд тусгахаар зохицуулах. ("гарагч" гэснийг "гаргагч" гэх) 2. Үйлдвэрлэлийн хүчин чадал, үйл ажиллагааны талаар зээлдэгчийн адил судалж, тэмдэглэсэн байх зохицуулалтыг хуулиас хасах, Монголбанк, СЗХ-ны журамд шаардлагыг тусгах.
	24.5.Зээлийн ашиглалтыг шалгасан материалд авсан зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж байгаа эсэхийг тодорхой тоо хэмжээ, үнийн дүнгээр нь тодорхойлж бичнэ.	Хэвээр үлдсэн	Энэ заалтыг хасах, Монголбанк, СЗХ-ны журамд шаардлагатай зохицуулалтыг тусгах.
	24.6.Зээлдүүлэгч нь зээлдэгчээс <u>зээлийн үйл ажиллагаатай</u> холбоотойгоос бусад баримт бичиг шаардахыг хориглоно.	Өөрчлөн найруулсан	"...зээлийн үйл ажиллагаатай..." гэснийг "...зээлээр санхүүжүүлсэн үйл ажиллагаатай..." гэх. Эсхүл зээлийн үйл ажиллагаа гэдгээр өөр зүйлийг илэрхийлж байна уу?
25 дугаар зүйл.Зээлийн батлан даалт	25.1.Зээлдэгч нь авсан зээл, түүний хүүг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлж чадахыг зээлдүүлэгчийн өмнө баталж, хэрэв төлж чадахгүй бол түүний нэрийн өмнөөс уг төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэх үүргийг гуравдагч этгээд хүлээхийг зээлийн батлан даалт, батлан даалт гаргасан этгээдийг батлан даагч гэнэ.	Хэвээр үлдсэн	25 дугаар зүйл. "Зээлийн батлан даалт" гэснийг "Зээлийн баталгаа, батлан даалт" гэх. Энэ зүйлд баталгаатай холбоотой зохицуулалтыг нэмэх. Батлан даалтаас хэрхэн ялгах, гэрээний зохицуулалт юу байх, баталгаа, батлан даалтын ялгаатай болон ижил зохицуулалтыг нэгтгэж тусгах.
	25.2.Зээлдэгч нь <u>Иргэний хуульд</u> заасан шаардлагын дагуу батлан даагчтай гэрээ байгуулна.	Өөрчлөн найруулсан	"Зээлдэгч нь..." гэснийг "Зээлдүүлэгч нь..." гэх
	25.3.Батлан даагч хүлээсэн үүргээ хууль, гэрээнд заасны дагуу биелүүлж, зээлдэгчийн нэгэн адил хариуцлага хүлээнэ.	Хэвээр үлдсэн	Батлан даалтын гэрээгээр батлан даагчийн хүлээх, үүрэг хариуцлагыг зохицуулна гэж ойлгож байна. Иймд "...зээлдэгчийн нэгэн адил хариуцлага хүлээнэ" гэснийг хасах.

	25.4.Батлан даагч нь санхүүгийн хувьд уг зээлийн төлбөрийг хийх чадвартай, үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөтэй этгээд байна. Батлан даагчийн санхүүгийн чадварын талаар үйлчлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, улсын бүртгэлд бүртгэсэн байгууллага тодорхойлолт гаргаж болно.	Хэвээр үлдсэн	Бүх болзлыг хангах шаардлага байхгүй буюу заавал үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөтэй байхыг шаардахгүй байж болно. Батлан даагчаас үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөөр баталгаа гаргуулах, түүнтэй холбоотой харилцааг барьцааны гэрээгээр зохицуулна. Тодорхойлолт гаргах зохицуулалт юуны тулд тодорхойлолт гаргуулах гээд байгаа нь ойлгомжгүй байна. Батлан даагчтай холбоотой судалгааг хийх, зээлийг батлан даах чадавхийг тогтооход хийх судалгааг Монголбанк, СЗХ-ны журмаар зохицуулах боломжтой тул <u>энэ заалтыг хасах</u> . Банк, <u>мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд</u> гэсэн байгаа нь энэ заалт зөвхөн банк, хадгаламж, зээлийн хоршоонд хамаарах зохицуулалттай байгааг өөрчлөх шаардлагатай.
	25.5.Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр буюу батлан даагч зээлдэгчийн өмнөөс хүлээсэн үүргээ биелүүлснээр батлан даалт дуусгавар болно.	Хэвээр үлдсэн	буюу гэсэн хэллэг нь өмнөх агуулгаа бататгасан агуулгаар ордог. Иймд "Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр, <u>эсхүл</u> батлан даагч зээлдэгчийн өмнөөс хүлээсэн үүргээ биелүүлснээр..." гэх
26 дугаар зүйл.Зээлийн барьцаа	26.1.Зээлийн барьцаатай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.	Өөрчлөн найруулсан	Энэ заалтыг доорх байдлаар дэлгэрүүлэн тусгах. "26.1. Зээлдэгч зээлийн гэрээнд заасан хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй тохиолдолд үүргийн биелэлтийг хангуулахаар зээлдэгчээс болон гуравдагч этгээдээс барьцаалсан эд хөрөнгө, эдийн бүс хөрөнгө, эрх нь зээлийн барьцаа болно. Барьцаатай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна." гэх. Зээлийн барьцааны тухай тусгай хууль байхгүй, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бүс хөрөнгийн барьцааны тухай хууль зэрэг нь бүх төрлийн үүргийн гүйцэтгэлд хамаарах бөгөөд Иргэний хуульд нийтлэг зохицуулалтыг тусгасан байх тул найруулгыг өөрчлөх.
27 дугаар зүйл.Зээлийг хугацаанаас өмнө буцаан төлөх	<u>27.1.Зээлдэгч гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө хэдийд ч зээлийн гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэж болно.</u>	Шинээр оруулсан	Хугацаанаас өмнө зээлийг буцаан төлөхөд олон улсын практикт тогтсон нэмэлт төлбөр, шимтгэл зэрэг хариуцлага тооцож болох эсэх, эсхүл хориглох зохицуулалтыг нэмж тусгах эсэх.
	<u>27.2.Зээлдэгч гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэсэн тохиолдолд зээлийн гэрээ дуусгавар болно.</u>		Өмнө дурьдсанчлан, зээлийн ерөнхий нэг гэрээ байгуулаад, зээлийн шугам, зээлжих эрхийн хүрээнд олон дахин зээл авах, төлөх тохиолдолд зээлийн гэрээ дуусгавар болохгүй, хүчинтэй байна. Мөн зээлийн хугацаа нь зээл олгох тухай бүрт тогтоогддог тул энэ заалтыг дараахь агуулгаар тусгах, эсхүл уг заалтыг хасах. "27.2.Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, зээлийг хугацаанаас өмнө буцаан төлсөн тохиолдолд <u>зээлийн гэрээгээр хүлээсэн үүрэг</u> дуусгавар болно." гэх.

28 дугаар зүйл.Зээл төлүүлэх	28.1.Зээлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу зээлийг эргүүлэн төлөх үүргийг зээлдэгч хүлээнэ.		Хуулийн төслийн 21.8 дахь заалтын хоёр дахь хэсэгт тусгасан зээлийг хугацаанаас өмнө төлүүлж болох заалтыг энэ зүйлд тусад нь заалт болгон нэмж оруулах.
	28.2.Зээлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол зээл, зээлийн хүүг төлөх хугацаа болмогц зээлдэгч, <u>хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч, баталгаа гаргагч, батлан даагчийн дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргалдах журмаар төлүүлнэ.</u>	Өөрчлөн найруулсан	"...зээл, зээлийн хүүг..." гэснийг "...зээлийн төлбөрийн үүргийг..." гүйцэтгэх хугацаа болмогц гэх
	28.3.Зээлийн төлбөр төлүүлэх, өр барагдуулах зорилгоор эд хөрөнгийг түр эзэмших болон өмчлөх, үйл ажиллагааны зардлаа нөхөх зориулалтаар хөлслүүлэх, түрээслүүлэх, худалдах үйл ажиллагаа нь зээл төлүүлэх үйл ажиллагаанд хамаарна.	Шинээр оруулсан	Энэ заалтыг хасах эсхүл өөрчлөн найруулахгүй бол Үндсэн хуулийн цэц дээр унах магадлалтай. "...зорилгоор эд хөрөнгийг..." гэснийг "...зорилгоор барьцаалсан эд хөрөнгийг" гэх. Мөн түр эзэмших, түр өмчлөх гэсэн ойлголт байхгүй. Мөн шууд эд хөрөнгийг нь өмчлөх эрх үүсэх үү гэдгийг бусад хуульд болон тэдгээрт орохоор төлөвлөгдөж байгаа зохицуулалтад нийцүүлэн тусгах.
29 дүгээр зүйл. Зээлийг ангилах	29.1. Зээлдүүлэгч олгосон зээлдээ судалгаа хийж, зээлийнхээ үлдэгдлийг хуульд заасны дагуу ангилна.	Өөрчлөн найруулсан	Зээлийн ангиллыг Монголбанк, СЗХ-ноос Сангийн яамтай хамтран баталсан журмын дагуу ангилж, сан байгуулдаг. Зээлийн болзошгүй эрсдэлийн санг Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хийгдэх шаардлага тавигддаг. Иймд энэ заалтад дурьдсан хуульд заасны дагуу гэснийг засах. Мөн зээлийн эрсдэлийн сан байгуулах тухай зохицуулалтыг нэмж тусгах.
ТАВДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ			
30 дугаар зүйл. Банк, эрх бүхий этгээдийн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт	30.1. Банкны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, банк, эрх бүхий хуулийн этгээдийн шилжүүлгийн үйл ажиллагаанд Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдийн хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хяналт шалгалтын чиг үүргийн хүрээнд дүрэм, журам баталж, хэрэгжилтэд хяналт тавина.	Өөрчлөн найруулсан	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд энэ хууль болон ҮТСтХ-д нийцүүлэн шаардлагатай өөрчлөлтийг оруулах зайлшгүй шаардлагатай.
ЗУРГАДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ			
31 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	31.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.		